

# **Бизнесийн ба эдийн засгийн мэдээ сурвалжлага**

*Компаниуд, санхүүгийн зах зээл, эдийн  
засгийн ерөнхий асуудлыг мэдээлэх нь*

Аня Шиффрин, Маргий Фрийний,  
Жэйн М. Фолпе



## **Сэтгүүлчдийн Олон Улсын Төв**

Мэргэжлийн чөлөөт хэвлэлгүйгээр ардчилал хөгжин цэцэглэж чадахгүй. Гэсэн хэдий ч олон оронд чөлөөт, мэргэжлийн хэвлэл мөрөөдөл хэвээр байсаар байна. Мянга мянган хүн өөрсдийн үзсэн, харсан, уншсан зүйлдээ итгэж үл чаддаг.

Сэтгүүлчдэд мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх сургалт дутагдаж байна. Бас олон сэтгүүлч хүнд, аюултай нөхцөлд ажиллаж байна. Түүнээс ч олон сэтгүүлч маш бага цалинтай болохоор давхар ажил эрхэлж буй нь үндсэн ажилтай нь зөрчилдөж байдаг. Түүгээр ч барахгүй сайн менежмент бүхий, санхүүгийн хувьд бие даасан хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх үзэл санаа ч цоо шинэ зүйл мэт санагдах нь олонтаа.

Ийм учраас Сэтгүүлчдийн Олон Улсын Төв (СОУТ) нь хамтран зүтгэгчидтэйгээ хүчтэй, бие даасан хэвлэлийг бий болгохын төлөө өдөр тутам ажиллаж байна. Энэ нь төр засгийг шударга байлгадаг хэвлэл, эрх мэдэлтнүүдэд хариуцлага хүлээлгэдэг сэтгүүлчид, бизнесийг ил тод болгодог хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүнчлэн үнэн бодит, итгэл үнэмшилтэй мэдээ бүхий хэвлэл байх юм.

СОУТ нь сүүлийн 20 жил дэлхийн өнцөг булан бүрийн мэргэжил нэгт нөхөдтэйгээ ажил мэргэжлийн шилдэг туршлагаасаа хуваалцаж байна.

## Талархал

Нэгдүгээр бүлгийг зохиогч **Маргий Фрийний** (Margie Freaney) нь *Атлантагийн Бизнесийн Сэтгүүлийн* (Atlanta Business Journal) гүйцэтгэх редактор, *Балтиморийн Бизнесийн Сэтгүүлийн* (Baltimore Business Journal) редактороор тус тус ажиллаж байсан. Тэрээр Словакт Найтын Олон Улсын Хэвлэлийн газар (*Knight International Press*) судлаачаар ажиллаж байхдаа тус улсын хамгийн нэр нөлөөтэй бизнесийн тэргүүлэх шинэ сонин болох *Тренд* (Trend) сониныг эрхлэн гаргаж, хөгжүүлэхэд тусалж байсан. Хамгийн сүүлд Гүржийн Тбилис хот дахь Кавказийн сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдлагын сургуульд үүсгэн байгуулагч, эрдэм шинжилгээ хариуцсан захирлаар хоёр жил ажилласан.

2-4 дүгээр бүлгийг зохиогч **Аня Шиффрин** (Аnya Schiffrin) нь Колумбийн Их сургуулийн Олон улсын харилцаа, төрийн удирдлагын сургуульд олон улсын бизнесийн ба эдийн засгийн мэдээ сурвалжлага сэдвээр хичээл заадаг туслах профессор. Шиффрин одоогоор Колумбид төвтэй эдийн засагчдын олон улсын сүлжээний байгууллага болох Бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх санаачилга (*Initiative for Policy Dialogue*) байгууллагад сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрийн захирлаар ажилладаг, <http://www.journalismtraining.net> вэб сайт бий болгосон. Колумбийн Их сургуулийн Найт-Багехотын судлаач (Knight-Bagehot Fellow) асан Шиффрин бизнесийн сэтгүүлчийн мэргэжлээр 10 жил ажилласан туршлагатай. Тэрээр Истанбулд төвтэй өдөр тутмын Турк Таймс (*The Turkish Times*) сонинд ерөнхий редактор, Испанийн Барселон дахь Ройтерийн орон тооны бус сэтгүүлч, Нью-Йоркийн Индастри Стандарт (*Industry Standard*)-н санхүүгийн тэргүүн нийтлэлч, Нидерландын Амстердам, Вьетнамын Ханой дахь Доу Жонс Ньюсвайрес (Dow Jones Newswires)-н товчооны даргаар ажиллаж байсан. Түүнчлэн бусад олон ном бичихэд хувь нэмрээ оруулсан.

Тавдугаар бүлгийг зохиогч **Жэйн М.Фолпе** (Jane M.Folpe) Колумбийн Их сургуулийн Сэтгүүл зүйн сургуулийн хөтөлбөрийн зохицуулагч, Барселоны буюу Лес Хойресийн Их сургуулийн (Barcelona/Les Heures) сэтгүүл зүйн магистрийн хөтөлбөрийн газарт компьютерийн тусламжтай мэдээ сурвалжлагын чиглэлээр лекц уншдаг. Энэхүү бүлэгт орсон материалуудыг түүний Барселоны буюу Лес Хойресийн Их сургууль болон бусад газар заасан компьютерийн тусламжтай мэдээ сурвалжлагын хичээлээс авав. Дэлгэрэнгүй мэдээллийг Аня Шиффрин, Амер Бисат нарын бичсэн “*Даяаршлын тухай мэдээлэх нь: Сэтгүүлч сурвалжлагч нар т зориулсан гарын авлага*”, Колумбийн Их сургуулийн хэвлэл, 2004 оны 11-р сар (*Covering*

*Globalization: A handbook for Reporters, Columbia University Press*) номонд Жэйн М. Фолпегийн бичсэн “Олон улсын бизнесийн мэдээ бэлтгэхэд Интернэтийг хэрхэн ашиглах вэ” (*How to Use the Internet to Cover International Business Stories*) гэсэн хэсгээс үзнэ үү.

СОУТ-ийн дэд ерөнхийлөгчөөр 13 жил ажиллаж байгаа **Вэйн Диллехэй** (Wayne Dillehay) энэхүү гарын авлагыг хянан тохиолдуулав.

Мөн энэхүү төсөлд зөвлөгөө өгч байсан СОУТ-ийн хөтөлбөрийн дэд захирал **Патрик Батлерт** (Patrick Butler) тусгайлан талархал илэрхийлье. СОУТ-ийн харилцааны менежер **Дэббий Ходжес** (Debbie Hodges) редакторын дэмжлэг үзүүлж, **Жилл Галлагер** (Jill Gallagher) уг гарын авлагын эхийг бэлтгэж, нэр томъёоны тайлбар гаргахад **Ирене Каушански** (Irene Kaushansky) туслав.

# Гарчиг

Оршил.....	7
Нэгдүгээр бүлэг: Бизнесийн ба эдийн засгийн мэдээ сурвалжлагын үндсүүд .....	8
<i>Маргий Фрийний</i>	
Хоёрдугаар бүлэг: Компаниудын тухай мэдээлэх нь.....	13
<i>Аня Шиффрин</i>	
Гуравдугаар бүлэг: Эдийн засгийн ерөнхий асуудлыг мэдээлэх нь .....	21
<i>Аня Шиффрин</i>	
Дөрөвдүгээр бүлэг: Бараа, түүхий эдийн тухай мэдээлэх нь .....	33
<i>Аня Шиффрин</i>	
Тавдугаар бүлэг: Бизнесийн ба эдийн засгийн мэдээ сурвалжлагад интернэтийг ашиглах нь .....	39
<i>Жэйн М.Фолле</i>	
Хавсралт А: Бүс нутгийн вэб сайтууд .....	47
Хавсралт Б: Нэр томъёоны тайлбар.....	49



# Оршил

**Д**элхийн улс орнуудын эдийн засаг улам бүр нэгдмэл, харилцан хамааралтай болж байгаа өнөө үед бизнесийн чиглэлийн чадварлаг сурвалжлагчид мэдээний аль ч редакцийн маш чухал хэсэг болсоор байна.

Дэлхий дээрх мэдээний аль ч агентлаг дундаж иргэний хувийн санхүүтэй холбоотой асуудал ч бай, дэлхий нийтийн эдийн засгийн бодлогын асуудал ч бай мөнгөний талаар байнга мэдээлж байдаг. Гэвч энэхүү чухал чиглэлээр уншигч, үзэгчдэд ашигтай, чухал мэдээлэл өгөх зорилго бүхий олон сурвалжлагч энэ талын сургалтанд одоог хүртэл хамрагдаагүй буюу дадлага туршлагаар дутмаг байдаг. Энэхүү гарын авлага нь бизнесийн ба эдийн засгийн мэдээ, сурвалжлагыг хэрхэн сайжруулах талаар зарим үндсэн санал, зөвлөгөө өгөх болно.

Санхүүгийн ажил гүйлгээ, эдийн засгийн өсөлт хөгжил, зах зээлийн нөхцөл байдлын талаар нягт нямбай мэдээллээр хангах нь ардчилсан орнуудын өсөлт, хөгжилд онцгой чухал ач холбогдолтой. Чөлөөт хэвлэлийг бүрэн хүлээн зөвшөөрөх дургүй засгийн газартай улс оронд ч бизнесийн ба эдийн засгийн мэдээ, мэдээлэл нь нягт нямбай, тэнцвэртэй, нээлттэй биш бол ийм мэдээлэл байгаад ч хэрэглэх нь хомс байдаг.

Энэхүү гарын авлага нь бизнесийн ба эдийн засгийн мэдээ сурвалжлагын үндсийг заах бөгөөд түүнчлэн компаниуд, бараа түүхий эд, банкны үйл ажиллагаа, ерөнхий эдийн засаг зэрэг онцлог асуудлыг гүнзгийрүүлж авч үзнэ. Бүлэг бүрт аливаа асуудлыг сурвалжлахад эх сурвалжийг хэрхэн олж авах, бичлэгийн санааг хэрхэн гаргах талаарх зөвлөгөө өгөгдсөн болно. Сүүлчийн хэсэг нь бизнесийн ба эдийн засгийн мэдээллийн онлайн эх сурвалжуудыг олж авахад зориулагдав.

# Бизнесийн ба эдийн засгийн мэдээ, сурвалжлагын үндсүүд

## Маргий Фрийний

**Д**элхийн хот, бүс нутаг бүр хэмжээнээсээ үл хамааран уншигч, үзэгчдийн өдөр тутмын амьдрал, тэдний хэтэвчин дэх мөнгөнд нөлөөлөх бизнесийн болон эдийн засгийн сонирхолтой нийтлэл, мэдээгээр дүүрэн байдаг.

Эдгээр нийтлэл, мэдээг хүмүүст түрүүлж хүргэх нь долоо хоногийн болон өдөр тутмын жижиг сонин хэвлэл, хэвлэл мэдээллийн бусад газруудын хувьд өрсөлдөөнд ялах боломжийг олгодог.

Бизнесийн мэдээний хувьд тоо баримт, тусгай өгөгдөл нь шийдвэрлэх ач холбогдолтой. Энд “ямар үнэтэй?”, “хичнээн хэмжээний?”, мөн “хэн, юу, хаана, хэзээ, яагаад?” гэсэн үндсэн асуултыг асууна.

Жишээ нь, байшин худалдах тухай мэдээнд байшингийн худалдах үнэ, хэмжээ, хэзээ баригдсан, тэнд хамаарах өмч хөрөнгийн хэмжээг оруулах ёстой бөгөөд эс тэгвэл мэдээ бүрэн бус болох юм.

Эмнэлгийн шинэ дэг журмын тухай жирийн нэг мэдээ ба уг дэг журмын тухай бизнесийн мэдээ хоёрын ялгаа нь ихэвчлэн тоон илэрхийлэл байдаг: Шинэ дэг журам хэр үнэ өртөгтэй вэ? Энэ үнэ өртөг нь хуучин дэг журмын Үнэ өртөгтэй харьцуулахад ямар вэ? Энэ шинэ дэг журмаас хэн эсвэл юу мөнгө олж байна вэ, эмч нар уу, эмнэлэг үү, үйлдвэрлэгчид үү, эмийн Үйлдвэрлэлийн компани уу?

Бизнесийн сурвалжлагч хүн мөнгө, түүний зарцуулалтын талаар асуух, бэлэн хариулт үгүй бол лавшруулж тодруулахаас хэзээ ч буцах ёсгүй.

Өөр нэг ялгаа бол бизнесийн сурвалжлагч аливаа асуудалд ямар өнцгөөс, яаж хандаж байгаа хандлагад оршино. Жишээ нь, засгийн газрын татаасаар шинэ орон сууцаар хангах ажлын талаар бичихдээ, жирийн сурвалжлагч нь уг байрыг түрээсээр эзэмшигчдийг хэрхэн сонгох, тэд түрээсэнд хэдийг төлөх, улс төрийн талаас болон хөршүүдийн зүгээс энэ ажлыг дэмжиж, эсэргүүцэж байгаа талаар голлон сонирхох бизээ.

Харин бизнесийн сурвалжлагчийн хувьд уг төслийн барилгын ажлын тендерт аль гүйцэтгэгч шалгарсан, гэрээ хэдий хэр үнэ өртөгтэй байх, барилгыг барих явцад болон төслийг хожим удирдан явуулахад хэдэн ажилтан авч ажиллуулах, төслийг санхүүжүүлэх мөнгийг хаанаас гаргах, энэ мөнгийг хэрхэн эргүүлэн төлөх зэргийг тодруулж мэдэхийг хүсэх болно.



## Эх сурвалж бий болгох явдал зайлшгүй чухал

Сурвалжлагч хүн аливаа бизнесийн мэдээ бэлтгэхдээ мэдээлэл авч болох янз бүрийн эх сурвалжуудтай байх шаардлагатай. Ихэнх тохиолдолд, сурвалжлагч дээд удирдлагаас нь эхлээд, шийдвэр гаргагч нараас ярилцлага авахыг хичээх ёстой.

Жишээ нь, ямар нэг компаний тухай бичихдээ ерөнхий менежер юмуу даргатай нь ярилцахыг хичээ. Ихэнх тохиолдолд компанийн хэвлэлийн төлөөлөгч хэвлэл мэдээллийнхэнд мэдээлэл өгөх үүрэг хүлээсэн байдаг, олон компани мэдээллээ үүгээр хязгаарлахыг хичээдэг. Гэвч тухайн пүүс компанийн бизнесийн стратегийг хамгийн сайн хэлж чадах хүмүүс бол бизнесийн дээд удирдлагууд байдаг, тэд л тодорхой, чухал мэдээллийг өгч чаддаг.

Аливаа байгууллагын ерөнхий нягтлан бодогч, санхүү хариуцсан захирал, эсвэл ахлах нягтлан зэрэг “олон тооны” хүмүүс төсөв, санхүүгийн бусад тайлангуудын нарийн төвөгтэй асуудлуудын талаар тайлбарлаж туслах нь олонтаа учир тэднийг үнэ цэнэтэй бусад эх сурвалжид тооцдог.

Бизнесийн сурвалжлагч нар тухайн нийгэмд байгаа бизнесийн тэргүүлэх хүмүүстэй уулзаж таньж мэддэг болох, мэдээ сурвалжлагын явцад тогтоосон харилцаагаа бэхжүүлэхийн төлөө ямагт хүчин чармайлт тавьдаг байх ёстой. Эдгээр эх сурвалжууд нь бизнесийн суурь мэдлэг, мэдээ сурвалжлага бичихэд зөвлөгөө өгөөд зогсохгүй бизнесийн ба эдийн засгийн хэтийн төлвийн талаар ч мэдээлэл өгч чадна.

## Мэдээг хаанаас, хэрхэн олж авах вэ

Бизнесийн мэдээгээр юуны ч тухай бичиж болох боловч тодорхой салбар хариуцуулан хуваарилалт хийх нь сурвалжлагч, редакторуудад ерөнхий дүр зургийг бүхэлд нь ажиглахад тусалдаг. Бизнесийн мэдээ нь дараахь гол салбарыг хамардаг:

- **Үл хөдлөх хөрөнгийн**, нэн ялангуяа шинэ барилга байгууламжийн борлуулалт, гүйлгээ
- **Банк санхүүгийн**, ялангуяа зээлийн бодлого, хүүгийн хувь хэмжээ, шинэ банкууд төрөн гарч хөгжих хандлага

Бизнесийн сурвалжлагч мөнгө, түүний зарцуулалтын талаар асуух, хэрэв бэлэн хариулт үгүй бол лавлаж тодруулахаас хэзээ ч буцах ёсгүй.

- **Эрүүл мэндийн салбар**, үүнд эмнэлэг, эмчилгээний газрууд, эмч, сувилагч нар, эмийн сангууд, эм хангамж болон эмчилгээний тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид, эрүүл мэндийн даатгалын компаниуд
- **Жижиглэн худалдаа**, үүнд супермаркет, гутал хувцасны дэлгүүр, гоо сайхны салон, тоглоомын дэлгүүр, хими цэвэрлэгээний газар, видео ба хөгжмийн худалдаа, гэр ахуйн бараа, тавилгын дэлгүүр, түүнчлэн хэрэглэгчид мөнгөө хаана, хэрхэн зарцуулахад нөлөөлж буй хүчин зүйл, чиг хандлага
- **Технологи**, ялангуяа хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, жижиглэн худалдаа, үл хөдлөх хөрөнгө, зочид буудал, ресторан зэрэг салбарт гарч буй шинэ санаачлага, чиг хандлага
- **Хөдөлмөр**, хөдөлмөрийн зах зээл дэх ажил мэргэжлийн төрөл, цалин хөлс, ажлын байранд гарч буй өөрчлөлт
- **Зочид буудал, ресторан, аялал жуулчлал**, ялангуяа жуулчдыг татах шинэ оролдлого, дэд бүтцийг сайжруулах чиглэлийн хүчин чармайлт
- **Дампуурал, өргөтгөл, франчайз, тодорхой салбар дахь ажиллах хүчний хомсдол** эсвэл илүүдэл

### **Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, спорт, зар сурталчилгаа/хэвлэл мэдээлэл**

Хэвлэлийнхэнд зориулсан мэдээнээс зайлсхий, мэдээг лавлаж тодруул Бизнесийн сайн сурвалжлагч нь болсон үйл явдлын талаарх мэдээллийг зөвхөн хэвлэлийн хуудас, хэвлэлийн бага хурлаас олж мэдэх ёсгүй. Харин бизнесийнхний хүрээн дэх олон янзын эх сурвалжтай тогтоосон байнгын харилцаа холбоогоо ашиглан тухайн мэдээг ямагт түрүүлж олж авахыг эрмэлзэх ёстой. Хэвлэлд зориулсан мэдээ гарах эсвэл хэвлэлийн бага хурал хийх үед мэдээлэл анх авч буй сурвалжлагч бол зүгээр л уг мэдээг дамжуулж буй олон хүмүүсийн нэг юм.

### **Тоо баримтыг уншигч, үзэгчдэд ойлгомжтой болго**

Аливаа бизнесийн мэдээний амин чухал бүрдэл бол тоо баримт боловч тэдгээрийг ойлгомжтой, энгийн байдлаар хүргэх шаардлагатай. Тоо баримтыг харуулахдаа аль болох бүдүүвч зураг, график ашигла. Энэ нь олон статистик тоо баримт бүхий урт үргэлжилсэн догол мөрүүдээр дүүрэх явдлыг багасгаж өгдөг.

## Бизнесийн мэдээ бичих нь

**Бизнесийн сайн мэдээ нь бусад мэдээний адилаар уншигчдыг татах эхний догол мөр буюу удиртгалтай байх шаардлагатай. Зарим тохиолдолд, үнэхээр гайхалтай жинхэнэ шинэ мэдээ бүхий цөөн хэдэн гол тоо баримтыг дангаар ашиглах нь үр нөлөөтэй удиртгал болох үндэс болдог.**

**Жишээ:** *(Татвараас зайлсхийж, компаний хөрөнгийг буруугаар ашиглаж завшсан хэрэгт татагдсан нэгэн компаний захирлын тухай мэдээнээс авсан ишлэл, Марк Мэермонт, Лаурей П.Кохен нар, Уолл Стрийт сэтгүүл (The Wall Street Journal), 2002 оны 8 дугаар сарын 7)*

1998 онд Тусо International компаний гүйцэтгэх захирал Л.Деннис Козловский Бока Рэтон дах шинэ байрандаа нүүж орсон нь 15000 фут квадрат талбайтай, усан сан, теннисний талбай, усан оргилуур бүхий дундад зууны үеийн загвартай, усны эрэгт байрласан шилтгээн байлаа.

Хэдийгээр ноён Козловский Америкийн хамгийн өндөр цалинтай корпорацийн захирлуудын нэг байсан ч энэхүү элбэг тансаг байдлаа санхүүжүүлэхийн тулд өөрийн халаасандаа гар хийх хэрэг байсангүй. Харин түүний оронд Тусо компаниас авсан 19 сая \$-н хүүгүй зээлээр төлжээ.



**Сурвалжлагч мэдээг амьд болгон уншигчдыг татах, эсвэл уншигчид тоо баримтад тулгуурласан удиртгал хэсгээс залхаж болзошгүй гэдэг үүднээс тухайн мэдээний ерөнхий сэдэвтэй холбоотой нэг хүн, нэг үйл явдлыг ашиглах дуртай байх явдал олонтаа байдаг.**

**Жишээ:** *(Хөнгөн цагаан боловсруулагч томоохон компанийг нэгэн өрсөлдөгчдөө зарах болсон тухай мэдээнээс авсан ишлэл, Зак Колеман, Атлантагийн Бизнесийн Хуанли (Atlanta Business Chronicle), 1998 оны 3 дугаар сарын 30)*

Аллен Борн амархан худалдагдсангүй.

Америкийн Алюминиум компанийн (Alcoa) удирдагч, ерөнхий захирал Паул Х.О'Нийлл түүн рүү утасдаж, бүтэн сайны өглөө гэр рүү нь факс илгээж, Борнын удирдах зөвлөлийн гишүүдийг нэг бүрчлэн лоббидох зэргээр Борныг худалдаж авахаас хоёр жилийн өмнөөс түүнийг хоргоосон бөгөөд эцэст нь Алюмакс корпорацийн захирлууд компаниа 3.8 тэрбум \$-р худалдахыг зөвшөөрсөн байна.

“Тэд бидний араас шунан хөөцөлдөж байлаа” гэж Борн хэлээд “Тэд бидний хөрөнгө, бидний технологийг авахыг хүсч байна” гэлээ.

# Бизнесийн сайн мэдээний бүрдлүүд

Орон нутгийн бизнесийн мэдээ бичихдээ анхаарах зарим гол асуултыг энд дурдъя:

- Уг мэдээнд хэдэн эх сурвалж байна вэ?
- Энэ нь ямар бизнес болох, юу эрхэлдгийг энэ мэдээнд тодорхой тайлбарлаж байна уу?
- Мэдээг хэр амьд болгосон байна вэ – зөвхөн болсон явдал, тоо баримт тоочихоосоо илүү бодит хүмүүстэй биечлэн уулзаж, тэдний ярианаас иш татсан уу?
- Эх сурвалжууд нь асуудлын бүхий л талыг төлөөлж байна уу?
- Эх сурвалжуудын дотор давхардсан санаа байна уу? Давхардсан бол мэдээг эвдэхгүйгээр аль нэгийг нь хасах боломж байна уу?
- Энэ мэдээ “хэр үнэтэй вэ?”, “ямар хэмжээний?” гэсэн асуултыг тавьж, үүнд хариулж байна уу?
- Мэдээнд зайлшгүй байх шаардлагатай бүх тоо баримт орсон уу? Тэдгээрийг ойлгомжтойгоор харуулсан уу?
- Тоонууд ямар нэгэн утга агуулж байна уу? Итгэл үнэмшил төрүүлж байна уу?
- Мэдээнд зураг, график гэх мэт нэмэлт илэрхийлэл оруулах шаардлагатай юу?
- Мэдээ нь асуудлын ерөнхий нөхцөл байдлыг харуулж байна уу? Жишээ нь, жижиглэн худалдааны тухай мэдээнд хэн хэн өрсөлдөж байгаа, өрсөлдөөн шударга эсэх, уг зах зээлийн нийт хэмжээ ямар вэ гэдгийг тайлбарлаж байна уу?
- Мэдээнд ишлэл байна уу? Ишлэл нь утга учиртай эсэх, эсвэл зүгээр л мэдээг дүүргэж байгаа юм уу?

# 2 Компаниудын тухай мэдээлэх нь

## Аня Шиффрин

**К**омпаниудын тухай мэдээлэх нь бизнесийн мэдээ сурвалжлагын гол зүйл юм. Тухайн орны эдийн засагт шийдвэрлэх үүрэг бүхий том, жижиг компани улс орон бүрт байдаг. Мэдээний бараг бүх байгууллагад сурвалжлагч нарт тодорхой салбар, компани хариуцуулан хуваарилсан байдаг. Тухайн чиглэлийнхээ компаниудыг сайтар мэдэж байх нь сэтгүүлчийн ажлын нэг чухал хэсэг юм.

Компаниудын тухай сэтгүүлчдийн бичдэг мэдээний олон өөр төрлүүд байдаг. Гэвч тэдний ихэнхийнх нь анхаарлын төвд: Мэдээний амин зүрх болсон тэр асуудал тухайн компаний ашигт ажиллагаа, түүний хувьцаанд хэрхэн нөлөөлөх вэ? гэсэн энгийн асуулт тавигддаг. Энэхүү гол санааг дотроо хадгалж явах нь мэдээ, сурвалжлага нэгэнт хийсний дараа нэмэлт мэдээлэл цуглуулж, мэдээнийхээ бүтцийг гаргахад илүү дөхөмтэй болгох болно.

Хөгжиж буй орнуудын ихэнх компани хувийн эсвэл улсын өмч байдаг. Зарим тохиолдолд тухайн компани хөрөнгийн биржийн жагсаалтад орсон байдаг бөгөөд хөрөнгийн бирж нь нийтэд арилжаалагдаж буй компаниудын хувьцааг хувь хүмүүс худалдан авснаар хөрөнгө оруулан, хувь эзэмших боломж олгодог зах зээл юм. Хөгжиж буй орнуудад хөрөнгийн зах зээл харьцангуй жижиг, арилжаа нь хязгаарлагдмал байдаг.

Дараах зүйлүүдийн талаар мэдээлэх нь хэзээд ач холбогдолтойд тооцогддог:

- Компанийн орлогын дүн
- Шинэ бүтээгдэхүүн
- Маркетингийн шинэ санаачлага
- Компаниуд нэгдэх, нэг нь нөгөөгөө худалдан авах
- Хөдөлмөрийн маргаан
- Компанийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт
- Өмч хувьчлал
- Засгийн газрын оролцоо, зохицуулалт
- Өргөн хүрээтэй эдийн засагт шилжих
- Тухайн компанийн ажиллаж байгаа салбарын ерөнхий төлөв

### Энэ бүлэгт дараах сэдвүүд хөндөгдөнө.

- Эх сурвалжуудыг олж авах
- Өргөн хүрээтэй мэдээг орон нутагтаа тусгаж авах нь
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт
- Зах зээлийн үйл явдлын мэдээ
- Кейс судалгаа

- Тухайн компанийн үйл ажиллагаа явуулж буй салбарт нөлөөлж буй эдийн засгийн үзүүлэлтүүд
- Хувьцааг багцлах, хувьцаа шинээр гаргах, санал болгох  
Эдгээр асуудал нь хэрэглэгч, ажиллагсад, бэлтгэн нийлүүлэгчид, түгээгч борлуулагчдад төдийгүй аливаа компани ашигтай ажиллах эсэхэд нөлөөлдөг.

### **Эх сурвалжууд ба мэдээллийг олж авах нь**

Компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэх эх сурвалжийг бий болгох үйл явц нь бусад салбарынхтай адил байдаг. Энэ үйл явц нь сурвалжлагч бичих гэж буй хүмүүс, байгууллагынхаа тухай сайн мэдэж авахаас эхэлдэг. Үүнийг хэд хэдэн арга замаар хийж болно:

- Тухайн компанийн төв байранд очиж үзэх
- Тухайн компанийн үйлдвэрүүд, түгээгч, борлуулагч нартай уулзах
- Дээд удирдлагууд, менежерүүд, ажилчидтай нь уулзаж ярилцах
- Хуучин удирдлагууд, ажилтнуудтай нь уулзаж ярилцах
- Компаниас эрхлэн гаргасан ном хэвлэл, танилцуулга, жилийн тайлан, орлогын аливаа мэдээллийг анхааралтай уншиж судлах
- Гол гол хувьцаа эзэмшигч нартай нь уулзаж ярилцах
- Тухайн компанид өдөр тутам ажилладаггүй ч гэсэн зөвлөгөө, удирдлага, хяналтаар хангаж байдаг удирдах зөвлөлийн гишүүдтэй нь уулзаж ярилцах
- Бэлтгэн нийлүүлэгчид, борлуулагчидтай нь уулзаж ярилцах
- Компанийн олон нийттэй харилцах болон маркетингийн асуудал хариуцсан төлөөлөгч нартай уулзаж ярилцах
- Тухайн компанийн үйл ажиллагааг хянаж зохицуулж байдаг засгийн газрын зохицуулагч байгууллага, яамдуудын төлөөлөгчидтэй уулзаж ярилцах
- Өрсөлдөгчидтэй нь уулзаж ярилцах

Хэдийгээр та тодорхой нэг мэдээн дээр ажиллаагүй байгаа ч эдгээр ярилцлагыг хийж, судалгаа явуулбал хэрэг нь гарах л болно. Эндээс та оролцогч, голлон тоглогч нарыг таньдаг, тэд ч таныг мэддэг болох бөгөөд гэнэт шинэ мэдээ дуулдаг, танд яаралтай мэдээлэл хэрэгтэй болох үед тэд туслах болно.

Хөрөнгийн биржтэй улс орнуудад мэдээллийг ил тод байлгах зохицуулалтууд байдаг. Хөрөнгийн биржийн жагсаалтад орсон компаниуд орлогынхоо мэдээллийг жилд хоёроос дөрвөн удаа шинэчлэн гаргах, мөн санхүүгийн жилийн эцэст албан ёсны санхүүгийн тайлангаа гаргаж танилцуулдаг байж болно. Энэ төрлийн мэдээлэл гаргаж танилцуулах шаардлагатай компаниуд олон нийтэд зориулсан мэдээлэл гаргаад сурчихсан байдаг учраас хэвлэлийнхэнтэй ярилцахад харьцангуй бэлэн байдаг.

Мэдээж нээлттэй компаниудтай харилцахад тэднээс илүү их мэдээлэл олж авах давуу талтай. Харин тэд хэвлэлийнхэнтэй харилцаад сурчихсан, улмаар олон нийтэд үнэ цэнэтэй мэдээлэл өгөхөөсөө тухайн компаниа гэрэл гэгээтэй талаас нь харуулахад илүү чиглэсэн хэвлэлийн мэдээг тогтмол

гаргадаг болчихсон байдаг сул талтай. Энэ тохиолдолд сурвалжлагч нар тэднийг тухайн компанийн талаар сайн сайхан мэдээг үргэлж давтаад байхгүй болтол нь гүнзгий ухаж төнхөн, хүнд хэцүү асуултууд тавих нь чухал. Эргэн нягталж, үл итгэгч мэт ханд. Цаашдын төлөв, чиг хандлагынх нь тухай өөр бие даасан эх сурвалжуудтай ярилцаад үз.

Хөрөнгийн биржийн жагсаалтад ороогүй компаниуд илүү нууцлагдмал байх талтай бөгөөд төрийн өмчийн олон компаниуд баттай мэдээлэл байхгүй эсвэл гаргаж өгөхгүй байж болзошгүй. Жишээ нь Вьетнамд аливаа компани санхүүгийнхээ мэдээллийг зөвхөн компанийхаа дээд удирдлагуудад өгдөг байх нь олонтаа. Иймэрхүү нууцлагдмал компаниудын тухай бичихдээ тэдний нийлүүлэгчид, өрсөлдөгчид, борлуулагчидтай нь уулзаж ярих замаар тухайн компанийн дотно, гадна хоёр талын эх сурвалжийг хоёуланг ашиглах нь чухал.

### **Хэвлэлийн мэдээнээс цааш**

Олон компани сэтгүүлч, сурвалжлагч нартай өдөр тутамд харилцаж байх үүрэгтэй, хүн хүч сайтай олон нийттэй харилцах хэлтэстэй байдаг. Компанийн хэвлэлийн төлөөлөгч нар ажилд илүү тустай байж болох бөгөөд тэдэнтэй мэргэжлийн сайн харилцаа тогтоож хөгжүүлэх нь чухал байдаг. Тэд уулзалт ярилцлага зохион байгуулж, мэдээллийг хурдан түргэн авсан эсэхийг магадлаж, чухал суурь мэдээллээр хангаж, дээд удирдлагууд байхгүй үед тавьсан асуултад чинь хариулт өгч чадна.

Гэхдээ, мэдээж хэрэг компанийн төлөөлөгчийн ажил бол өөрийн компаниа сайн сайхан харагдуулах явдал бөгөөд чухал мэдээ гэж юу болох талаарх түүний бодол санаа сурвалжлагч хүнийхээс огт өөр байж болно. Компанийн төлөөлөгч нар өөрийн компанийхаа зөвхөн гэрэл гэгээтэй талаас харуулсан мэдээ материал хэвлэгдсэн байхыг илүү хүсэх бөгөөд улмаар компанидаа тулгарсан хүндрэл бэрхшээлүүдийг дутуу үнэлэх эсвэл үгүйсгэж болох талтай.

Аливаа компани орлого эсвэл хувьцааныхаа үнэд нөлөөлж болох ямар нэг зүйл хийх үед олон нийттэй харилцах хэлтэс нь хэвлэлийн мэдээ гаргах болно. Түүнчлэн тэд тантай холбоо барьж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж эсвэл шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлж байгаа тухайгаа мэдээлэхийг хүсч болно. Ийм тохиолдолд та тухайн компанийн хүсэн хүлээж буй зүйл үнэхээр бодитой эсэхийг олж мэдэхийг хичээх болно. Жишээ нь, нэг компани ихэнх хүмүүс нь ядуу амьдралтай, цөөн хүн л автомашин эзэмшдэг улс оронд автомашин үйлдвэрлэж эхлэх гэж байгаа бол уг төсөлд төлөвлөсөн борлуулалтын тоо хэмжээ бодитой эсэх талаар та асуух хэрэгтэй. Ихэвчлэн ийм компани хэт дэврэнгүй өөдрөгөөр төсөөлснөө хүлээн зөвшөөрөхгүй, тэгвэл та мэдээндээ суурь сэдэв, нөхцөл байдлын тухай мэдээллийг оруулж уншигч, үзэгчдэд энэ талаарх өөр үзэл бодлыг бас толилуулж болно. Иймэрхүү мэдээ сурвалжлага нь тухайн компанийн байр суурийг үзэгчид өөр өөрийнхөөрөө үнэлэхэд чухал ач холбогдолтой болох юм. Аливаа компанийн өрсөлдөгчид эсвэл өөр бусад бодитой эх сурвалжуудыг олж харж, уулзаж ярилцах нь тухайн мэдээнд дурдсан компанийн мэдэгдлийг тэнцвэржүүлж өгөх болно.

# Кейс судалгаа

## Агаарын дайны шинэ үе

Манай нэгдсэн товчооноос бэлтгэв (Энэтхэгийн Санхүүгийн Экспресс сэтгүүл буюу *Financial Express of India*-с авсан ишлэл, 2004 оны 6 дугаар сарын 23)

Шинэ Дели, 7 дугаар сарын 22 - Пүрэв гаригт Жет Аэрвэйз (Jet Airways) компани Дели-Мумбайгийн хоорондын нислэгт 2500 рупий, Дели-Калькуттагийн хоорондын нислэгт 3000 рупий, Дели-Банглорийн хоорондын нислэгт 3500 рупийгээр билет борлуулах шинэ тарифаа зарласнаар дотоодын нислэгийн тарифийн асуудлаарх зөрчил газар авсаар байна.

Энэ нь даваа гаригт Аэр Сахара (Air Sahara) компани өөрийн “Target Rail Ind AC” нэртэй стратегиа нийтэд зарласны хариу алхам байлаа.

Сахарагийн үнийн тариф (7 сарын 20-ны FE)-ийн нэг адил дээр дурдсан Жетийн үнэ ч бас зарим нь жирийн, энгийн ангиллын үнийн түвшинд гэхэд 69 хувь унасан харагдаж байв. Жишээлбэл, бүх секторт ямар нэг хөнгөлөлт үзүүлэхгүй болжээ. Маршрутаа өөрчлөх эсвэл ангилал буюу сектор солихыг зөвшөөрөхгүй. Билетийг нислэгээс 30 хоногийн өмнө урьдчилан худалдан авах шаардлагатай ба үнийн энэ санал нь 7 дугаар сарын 26-наас 10 дугаар сарын 15-ны хугацаанд хүчинтэй үйлчлэх юм байна.

Жетийн удирдлагууд шинээр зарласан тарифаа дааж дийлэхгүй ч, Сахарагийн санал болгосноос илүү хувилбарыг санал болгох гэж оролдохоос өөр арга байсангүй гэлээ.

Жирийн зорчигчидтой адилгүй нь энэ чиглэлийн мэргэжилтнүүд уг тарифийн зөрчил ямар учиртай болох талаар санал хуваагдаж байлаа. “Энэтхэгт үнэ тарифийг зохицуулалтгүй болгосон. Тэгэхлээр Жет нь

## Энэ мэдээнд анхаарвал зохих хэд хэдэн чухал бүрдэл байна:

- Өмнө нь мэдээлж байсан бөгөөд одоо үргэлжилж буй үйл явдлын тухай эргэн дүгнэж байна
- Энд олон эх сурвалжаас авсан мэдээлэл, хэтийн төлвийг оруулсан байна
- Нэгэн нисэх онгоцны компанийн гаргасан байж болох хэвлэлийн мэдээллийг энд зүгээр нэг давтан бичсэнгүй
- Жирийн хүмүүст төдийгүй нисэх онгоцны үйлчилгээний салбарт нөлөөлж болзошгүй үр нөлөөг авч үзсэн байна

ч юмуу, Сахара нь ч юмуу эсрэг тохиолдолд хоосон үлдэх зарим суудлуудаа дүүргэхийг хүсч байгаа бол санаа зовох бодитой асуудал байхгүй” гэж Иргэний агаарын тээврийн газрын ерөнхий захирал Х.С Хола хэлсэн юм. Мөн “Энэтхэгийн Иргэний агаарын тээврийн ерөнхий газар (DGCA буюу ИАТЕГ)-т тулгарч болох цорын ганц асуудал бол агаарын нислэгийн компаниуд суудлуудаа хамгийн доод үнээр 100 хувь санал болгоод эхлэх тэр цаг үед үүснэ” гэж Хола хэллээ. Ази, Номхон далайн агаарын тээврийн төвийн Капил Каул ч үүнтэй санал нэг байсан бөгөөд “Суудлын багтаамж 42 хувь илүүдэлтэй байгаа нь 10 сая зорчигчийн суудал гэсэн үг. Энэ уналтын байдал 7-9 сарын хооронд бүр дордож байна. Иймээс одоогийн тарифийн өөрчлөлт бол агаарын тээврийн компаниуд төмөр зам болон агаараар зорчиход гарах шилжилтийн цэгийг ойлгож эхлээд байгааг харуулж байна” гэж үзэж байлаа.

Өөр нэг мэргэжилтэн үүнтэй огт санал нийлсэнгүй. Тэрээр Энэтхэгийн зохицуулагч нар амь өрсөн үнэ тарифийн тухай ойлголт мэдлэг муутай байна гэлээ.



“Орцынхоо зардлыг ч нөхөж чадахгүй түвшинд үнэ тогтоох нь нислэгийн аюулгүй байдалд шууд нөлөөлнө гэсэн үг” гэж тэр хэлээд тэрээр нэрээ дурдахгүй байхыг хүссэн юм.

Төрийн хуучин албан хаагч асан Нареш Чандрагийн толгойлсон мэргэжилтнүүдийн баг дотоодын нислэгт агаарын тээврийн тарифийг бууруулах талаар нарийн судалгаа хийсэн байлаа. Гэвч энэхүү санаа нь орон нутгийн татвар, шатахууны үнэ, маршрутын навигац, буултын төлбөр, түрээсийн өртөг зэрэг орцын зардлыг зохих хэмжээгээр бууруулахад чиглэсэн байлаа.

Даваа гаригт Аэр Сахара компани ихээхэн хөнгөлөлт үзүүлэн уг зах зээлийг хутган үймүүлсэн билээ. Гэвч энэхүү үнийн санал нь тасалбарыг 30 хоногийн өмнөөс урьдчилан худалдан авсан байх болзолтой байсан юм.

Энэхүү мэдээг хэвлэлд өгөх мөч хүртэл улсын өмчийн Индиан Аэрлайнс (Indian Airlines) компанийн зүгээс ямар нэг алхам хийсэнгүй. Саяхан тус агаарын тээврийн компани онгоцоор зорчигчдод дөнгөж 1000-хан рупий нэмж төлөөд нэмэлт секторт зорчих боломжийг санал болгож байсан билээ.

## **Өргөн хүрээтэй мэдээг орон нутагтаа тусгаж авах нь**

Мэдээ бичих ажлын нэг чухал хэсэг бол олон улсын эсвэл үндэсний хэмжээний мэдээг авч ашиглах, ялангуяа компаниудын тухай мэдээлэх үедээ орон нутгийн өнцгөөс харж бичих явдал юм. Жишээлбэл, танай улсын засгийн газар Европтой юмуу АНУ-тай худалдааны шинэ гэрээнд гарын үсэг зурвал яах вэ? Гадаадын компаниуд өөр оронд үйл ажиллагаагаа өргөжүүлэх зөвшөөрөлтэй болбол ихэнх тохиолдолд дотоодын компаниудын хувьд ч дотооддоо үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ хилийн чанадад экспортлох зөвшөөрөлтэй болдог.

Худалдааны шинэ гэрээний дагуу гадаадын харилцаа холбооны нэгэн компани танай оронд илүү их хөрөнгө оруулалт хийх боломжтой боллоо гэж бодъё. Дотоодын компаниуд гадаадын компанийн өрсөлдөөнтэй тулгарч болох талаар ярьж, тэд өрсөлдөхөд хэр бэлэн байгааг болон санаа зовж байгаа эсэхийг олж мэдэх замаар энэ мэдээг орон нутгийн онцлог, нөхцөл байдалтай холбо. Тэд ажлын байрны цомхтгол хийнэ гэж үзэж байна уу, ажилчид нь энэ талаар юу гэж бодож байна вэ?

Сайн сурвалжлагч бол энэхүү шинэ гэрээнээс хэн хожиж, хэн хожигдож болох боломжийг олж харах үүднээс дотоодын нөхцөл байдлыг судлах болно. Маргааныг зохицуулах арга зам байна уу? Аль нэг орон энэхүү шинэ гэрээнээс хожиж, ийм гэрээг зохицуулж чадах олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн худалдааны шинэ дүрмүүдийн давуу талыг ашиглах боломжтой юу?

Цөөн хэдэн санал зөвлөмжийг энд дурдъя:

- Тухайн орны экспортлогчид шинэ гэрээний үр дүнд экспортоо нэмэгдүүлнэ гэж бодож байгаа эсэхийг мэдэхийн тулд тэдэнтэй очиж уулз
- Шинэ шаардлагад нийцүүлэх үүднээс тэд үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх хангалттай хөрөнгөтэй эсэхийг олж мэд
- Дотоодын компаниуд илүү их бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлохын тулд хангалттай импорт хийж байгаа эсэхийг олж мэд
- Дотооддоо үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн олон улсын экспортод өрсөлдөхүйц сайн чанартай эсэхийг олж мэд
- Олон улсын зах зээл дээр өөр бусад ямар орнууд өрсөлдөж байна, дотоодын компаниуд тэдэнтэй олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц хүчтэй эсэхийг олж хар
- Дотоодын дэд бүтэц болон боомтуудыг судалж, ачаа тээврийн нэмэлт хөдөлгөөнийг дааж чадах эсэх, тээвэрлэлтийн хугацаа хэр урт байгааг олж мэд.

### **Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухай мэдээлэх нь**

Хөгжиж байгаа орнуудын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) бол нэг томоохон мэдээ бөгөөд ийм хөрөнгө оруулалт сүүлийн арван жилд эрс өсч байна. ГШХО хамгийн их авч байгаа орон бол Хятад улс. ГШХО-ын тухай хамгийн нийтлэг мэдээ бол гадны компаниуд дотоодын компаниудыг худалдан авахаар эсвэл үйлдвэрлэл явуулахын тулд хоёр талаас хөрөнгө (газар, тоног төхөөрөмж гэх мэт), мөнгө нийлүүлэн хамтарсан үйлдвэр байгуулахаар шийдсэн тухай мэдээ байдаг.

Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ажлын байр бий болгож чадах учраас ГШХО хөгжилд чухал ач холбогдолтой гэж үздэг. Мөн, гадаадын компаниуд шинэ технологи, дэлхийн түвшний үйлдвэрлэлийн стандарт оруулж ирдэг бөгөөд дотоодын менежерүүдийг сурган, авч ажиллуулах нь олонтаа байдаг. Энэ бүхэн нь дотоодын компаниудад нөлөөлж, олон улсын зах зээл дээр хэрхэн өрсөлдөх талаар гадаадынхнаас сурч мэдэхэд тусалдаг.

Гэвч засгийн газрууд гадаадын компаниудыг ГШХО-н төлөвлөгөөнд заасан нөхцлүүдийнхээ дагуу хэтнөлөөлж байна гэж санаа зовох нь олонтаа бөгөөд улмаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг хязгаарлах хүчин чармайлт гаргаж болох юм. Жишээлбэл, олон орны засгийн газар хамтарсан үйлдвэрийн 49-өөс дээш хувийг гадаадынхан эзэмшихийг хязгаарласан байдаг.

### **Санхүүгийн зах зээлийн тухай мэдээлэх нь**

Зах зээлийн мэдээлэл гэдэг нь бонд, валютын ханш, хөрөнгийн зах зээл, нефть, будаа гэх мэт бараа түүхий эдийн худалдааны (Бүлэг 4-г үз) тухай

бичнэ гэсэн үг. Хөрөнгийн эсвэл бараа түүхий эдийн зах зээл чухал байдаг орнуудын сонин хэвлэлүүд тухайн зах зээлийн болон хаалтын ханшийн талаар өдөрт нэгээс хоёр мэдээг ихэвчлэн тавьдаг. Зарим зах зээлд, мэдээлэл холбооны газрууд болон мэдээний агентлагууд цөөн цаг тутамд өөр өөр зах зээлийн тухай мэдээг цацдаг. Хөрөнгийн болон бараа, түүхий эдийн зах зээл дөнгөж хөгжиж эхэлж байгаа орнуудад хүртэл олон нийтэд энэ талаар үнэн зөв, шуурхай мэдээллийг цаг алдалгүй хүргэх сэтгүүлчдийн үүрэг улам чухал болсоор байна.

Заримдаа сурвалжлагч ямар нэг зах зээлийн тухай байнга мэдээлэх нь дахин давтагдсан, нэг хэвийн уйтгартай ажил гэж үздэг. Эхэндээ зах зээлийн өөрчлөлтийн хурдыг гүйцэж мэдээлэх нь маш хэцүү ажил мэт боловч удалгүй ингэж мэдээлэх нь нэг хэвийн, байнгын шинжтэй болж хувирдаг. Гэвч зах зээлийн тухай мэдээлэх нь сэтгүүлч, сурвалжлагч нарт үнэ цэнэтэй сургалт болдог: энэ нь шинээр гарч байгаа мэдээнд маш хурдан хариу үйлдэл хийхийг заахын зэрэгцээ бусад төрлийн мэдээнд ашиглаж болохуйц эх сурвалжуудыг бий болгож хөгжүүлэхэд тусалдаг. Зах зээл хэрхэн яаж ажилладаг тухай бүрэн ойлгож мэдэхгүйгээр бизнесийн талаар томоохон, дүн шинжилгээний чанартай мэдээ бичих хэцүү.

Аливаа зах зээлийн мэдээний гол цэг бол тухайн зах зээлийн санхүүгийн нөхцөл байдлыг мэдээлэх явдал юм. Үүнийг зах зээлийн үнийн байдлыг минут минутаар тэмдэглэж гаргадаг янз бүрийн үзүүлэлт, индексүүдийг судлан шинжлэх замаар гүйцэтгэдэг. Түүнчлэн зах зээлийн үнэд юу нөлөөлж болохыг мэдээлэхийн тулд тухайн зах зээлийн гадаад хүчин зүйлсийг эрж хайх нь чухал. Эцэст нь, урт болон богино хугацаанд зах зээл хаашаа явж байна гэж хөрөнгө оруулагчид үзнэ, түүндээ тулгуурлаж бизнесийн шийдвэрээ гаргадаг учраас зах зээлийн тухай мэдээнүүд ихэвчлэн зах зээл хаашаа явах чиг хандлагатай байгааг урьдчилан таамаглахыг хичээдэг.

Зах зээлийн мэдээ, сурвалжлагад юуг өгүүлэх ёстой вэ?

- Худалдааны хэмжээ, үнийн хувьд уг зах зээл хаана явж байна вэ?
- Эдгээр үзүүлэлт, индексд ямар мэдээ нөлөөлж болох вэ?
- Бараа түүхий эдийн зах зээлийн тухай мэдээний хувьд цаг агаарын нөхцөл чухал байх нь олонтаа. Жишээ нь, ган болвол будааны үнэ өснө гэсэн үг.
- Гадаад хүчин зүйлс, үйл явдлууд шийдвэрлэх ач холбогдолтой байх нь олонтаа. Нефть үйлдвэрлэгч нэгэн оронд дайн гарах магадлал байгаагаас нефтийн үнэ өсч болох бөгөөд энэ таамаглалыг даган зах зээлийн үнэ өсч болно.
- Компани хүлээгдэж буй санхүүгийн үр дүнгээсээ илүү сайн ажиллаж

байгаагаа мэдээлвэл хувьцааных нь зах зээлийн үнэ өсч болох юм. Үнэ өсөх мэдээ хүлээж байсан хүлээлт ч эдгээр хувьцааны үнийг хөөрөгдөж болно.

### **Бизнесийн чухал нэр томъёо:**

**Бараа түүхий эд:** Бараа түүхий эд гэдэг бол хөрөнгө оруулагчид ихэвчлэн ирээдүйд худалдан авах гэрээгээр худалдаж, худалдан авч байдаг хүнсний бараа, метал болон өөр бусад биет зүйл юм.

**Шууд хөрөнгө оруулалт:** Аливаа компанийн дараа дараагийн шийдвэрт нөлөө үзүүлэхүйц хангалттай их хэмжээний хөрөнгө оруулалт.

**Гадаадын хөрөнгө оруулалт:** Нэг улс орны хувь хүн болон пүүс компани нь өөр улс орны хувь хүн, пүүс компанийн эд хөрөнгийг худалдан авах. Үүнд шууд болон үнэт цаасны портфелийн хөрөнгө оруулалт аль аль нь хамрагдана.

**Зах зээлийн үнэ:** Худалдагч ба худалдан авагч этгээдүүд бие биенээсээ хамааралгүй зөвхөн арилжааны ашиг сонирхлын үүднээс солилцоо хийж байгаа тохиолдолд ямар нэг зүйлийг худалдан авахад бэлэн байгаа этгээдээс түүнийг худалдахад бэлэн байгаа этгээдэд төлж байгаа мөнгөний хэмжээг хэлнэ.

**Нийлсэн компаниуд:** (1) Худалдан авагч тал бүх хөрөнгө, өр төлбөрийг нь шилжүүлэн авч байгаа худалдан авалт (2) Ерөнхий утгаараа, хоёр компани ямар нэг байдлаар нэгдэхийг хэлнэ.

**Хөрөнгийн зах зээл:** Мөн үнэт цаасны зах зээл гэж нэрлэх бөгөөд үнэт цаас арилжаалах зах зээлийг хэлнэ.

**Хувьцааг багцлах:** Энэ нь компани шинээр хувьцаа гаргах үед тохиолддог, ингэснээр хувьцааныхаа одоогийн зах зээлийн үнийг хувьцаа багцлахын өмнөх үеийн хувьцааны үнэтэй пропорционал түвшинд хүртэл бууруулахыг хэлнэ. Жишээлбэл, IBM компани 2:1 харьцаагаар багцлахын өмнө хувьцаагаа 100\$-р арилжаалж байсан гэвэл багцалсны дараа хувьцаагаа 50\$-р арилжаалах бөгөөд уг хувьцааг эзэмшигчид багцлахын өмнө эзэмшиж байснаасаа 2 дахин илүү тооны хувьцаа эзэмших болно гэсэн үг.

**Худалдааны хэмжээ:** Өгөгдсөн хугацаанд аюулгүйгээр арилжигдсан хувьцаа, бонд болон гэрээ хэлцлийн нийт тоо хэмжээ.

# 3 Эдийн засгийг бүхэлд нь мэдээлэх нь

**Аня Шиффрин**

**А**ливаа улс орны эдийн засаг бол олон янзын бүрэлдэхүүн хэсгийг хамарсан нарийн түвэгтэй цогц байдаг. Мэргэжсэн эдийн засагчид хүртэл түүнийг хөдөлгөн ажиллуулж байдаг бүх өөрчлөлтийг тэр бүр бүрэн мэддэггүй. Иймээс засгийн газрууд үр нөлөөтэй эдийн засгийн бодлого баримтлахад үнэхээр хэцүү болохыг мэдээд зогсохгүй нэг бодлогын оронд нөгөөг баримталсны эдийн засгийн үр дагаврыг урьдчилан тооцож чадахгүй байх нь олонтаа.

Сурвалжлагчдын хувьд энэ сэдвээр мэдээлэх нь маш ярвигтай байдаг. Тэд ихэвчлэн хийсвэр ойлголтуудын тухай урт түүх бичих дургүй, харин түүний оронд бодит үйл явдлууд, ягшсан тоо баримтад голлон анхаарахыг илүүд үздэг. Асуудлыг улам хүндрүүлж авч үзэх юм бол, эдийн засаг нь улс төр, үзэл суртал хоёртой нягт холбоотой байдаг учраас нэг төрлийн үзэл бодолтой хүмүүс нэг бодлогыг дэмжиж байхад өөр үзэл бодолтой хүмүүс бас өөр бодол санаатай байдаг. Жишээлбэл, зүүний чиглэлийн улс төрчид эдийн засгийн өсөлт, ажлын байр бий болгох талаар санаа зовох хандлагатай, зах зээл дэх төрийн зохицуулалтад итгэж байдаг. Харин барууны чиглэлийн улс төрчид голдуу үнийг доогуур түвшинд барихад санаа тавьж, улс оронд тулгарч байгаа эдийн засгийн олон хүндрэлтэй асуудлыг хувийн салбарынхан шийдвэрлэж чадах ба тиймээс тэдэнд өөрийнхөөрөө ажиллах эрх чөлөө олгох ёстой гэж үздэг. Мөн янз бүрийн эх сурвалжуудад нэг талыг барих хандлага ямагт байдгийг анхаарч, энэ үүднээс мэдээллийг үнэлж дүгнэж байх нь чухал.

Эдийн засгийн тухай мэдээлэх нэг арга бол үнэн чанартаа улс орон хэр ажиллаж байна вэ: хөгжиж байна уу, эсвэл доройтож байна уу, аль хэсэг нь өсч байна, яагаад өсөх болов, энэ өсөлт цаашид үргэлжлэх үү гэдэг талаар

## Энэ бүлэгт:

- Эдийн засгийн мэдээний бүрдлүүд
- Кейс судалгаа
- Учир шалтгааныг ойлгох нь
- Судалгааны институтүүд
- Эргэж төлөгдөөгүй зээл
- Банкны үйл ажиллагааны тухай хэдэн үг зэрэг сэдэв орсон .

бичих нь чухлыг ямагт санаж явах явдал юм. Засгийн газар юу хийж байна вэ, бодлого нь үр дүнтэй эсэхийг сайтар ажиглаарай.

Компаниудын талаар мэдээлэхийн тулд бол тоо баримтууд юу харуулж байгааг олж харах хэрэгтэй. Сайн сэтгүүлч бол тэр тоонууд дундаж иргэнд яаж нөлөөлж байгаад голлон анхаардаг. Жирийн хүмүүсийг мэдээнд оролцуулах нь тухайн мэдээ сурвалжлагыг илүү уншууртай, хамааралтай болгож, мэдээнд бичиж байгаа хүмүүст хийсвэр тоон үзүүлэлтүүд хэрхэн нөлөөлж байгааг тодорхой харуулж өгөх болно.

Эдийн засгийн сурвалжлагчид голдуу дараахь сэдвийг мэдээ сурвалжлагадаа хөнддөг:

### **Компаниуд болон ажлын байртай холбоотой сэдэв**

- Ажил эрхлэлтийн тоон үзүүлэлтүүд, засгийн газраас ажлын байр бий болгох, хөдөлмөрийн хуулиудыг өөрчлөх талаар тавьж байгаа хүчин чармайлт
- Худалдаа. Үүнд улс орнууд болон бүлэглэлүүдийн хоорондох гэрээ хэлэлцээр, түүний дотор худалдааны саад хоригийг багасгах, олон улсын худалдааг хөхүүлэн дэмжих талаар Дэлхийн Худалдааны Байгууллагатай хийсэн тохиролцоонууд орно.
- Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиуд. Эдгээр хуулинд орсон өөрчлөлт аливаа орны авч байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, бүтцэд нөлөө үзүүлж болно. Түүнчлэн гадаадын компаниудтай өрсөлдөх шаардлагатай дотоодын үйлдвэрлэлд ч нөлөөлж чадна. Шинэ зохицуулалтын тухай мэдээлэхдээ засгийн газрын ажилтнууд, гадаадын тэргүүлэх бизнесмэнүүд, гадаадын элчин сайдын яамдын худалдааны ажилтнууд, олон улсын хуульчид, худалдааны танхим гэх мэт гадаад, дотоодын бизнесийн холбоодын төлөөлөгч нартай уулзаж ярилцах нь чухал.
- Өмч хувьчлал. Энэ нь засгийн газраас төрийн өмчийн компаниудыг хувийн хөрөнгө оруулагч нарт эсвэл гадаадын компаниудад худалдахаар шийдвэрлэхийг хэлнэ.
- Дэд бүтцийн барилга, байгууламж. Эдийн засагт бүхэлд нь болон импорт, экспортын хэмжээнд нөлөөлөхүйц шинэ боомт газар, хурдны зам, нисэх онгоцны буудал зэргийг байгуулах буюу шинэчлэх явдал.

### **Засгийн газрын зарцуулалт**

- Засгийн газрын төсөв. Ер нь засгийн газрууд жил бүр шинэ төсвөө тарааж, орлогоо хэрхэн нэмэгдүүлэх, түүнийгээ хэрхэн зарцуулах тухайгаа тодорхойлдог.
- Татварын бодлого. Засгийн газар татварт хэнээс (бизнес, иргэн хувь

хүмүүс, бусад оролцогч талуудаас) хэр хэмжээний мөнгийг цуглуулахаа шийддэг. Татварын бодлогын талаарх мэдээллийг ихэвчлэн сангийн яамнаас гаргадаг.

- Нийгмийн хамгааллын сүлжээ. Нийгмийн зарцуулалтын хөтөлбөрийг (тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйчүүдэд үзүүлэх дэмжлэг гэх мэт) боловсруулах, баримтлах, санхүүжүүлэхэд ихэвчлэн засгийн газар гол үүрэг гүйцэтгэдэг нь шинэчлэл болон бүтцийн бусад өөрчлөлтийн үр нөлөөнөөс эмзэг хэсгийг хамгаалах зорилготой байдаг.

## Валют ба өр

- Гадаад валютын ханш. Дотоодын валютыг олон улсын өөр нэг валютаар, ихэвчлэн доллар, иен, еврогоор солих үед хэрэглэдэг үнэ.
- Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк эсвэл Америк хоорондын хөгжлийн банк гэх мэт олон улсын санхүүгийн байгууллагуудтай хийдэг гэрээ хэлэлцээр. Хөгжиж байгаа орнууд албан ёсны эх сурвалжуудаас, түүний дотор олон талт хамтын ажиллагааны байгууллагуудаас мөнгө зээлэх явдал олонтаа гардаг. Ийм байгууллагууд голдуу эдийн засгийн тодорхой бодлого баримтлах эсвэл шинэ бодлого хэрэгжүүлэхийг шаарддаг бөгөөд үүнийг “болзолт нөхцөл” гэж нэрлэдэг.
- Өрийн хэлэлцээр. Зээлийн тухай яриа хэлэлцээрийг өрийн хэлэлцээр гэх бөгөөд ихэнхдээ нэлээд сунжирч, хэдэн жилээр ч үргэлжлэх тохиолдол байдаг. Ийм яриа хэлэлцээр Лондоны Клуб гэх мэт хувийн зээлдүүлэгч бүлэглэлүүд, Парисын Клуб гэх мэт албан ёсны зээлдүүлэгч бүлэглэлүүдэд голдуу явагддаг.
- Батлан даалт. Зарим үед их хэмжээний өрийг эргүүлэн төлөх шаардлагатай болж, дампуурлын ирмэгт байгаа засгийн газар, компаниуд эсвэл банкинд их хэмжээний мөнгө оруулж хүнд байдлаас авардаг. Энэхүү батлан даалтын эх сурвалж нь Олон улсын валютын сан гэх мэт олон талт байгууллагууд байдаг бөгөөд бусад улс оронд нүүрлэсэн хямралт байдлыг намжаах, даван туулах хүсэл эрмэлзэлд хөтлөгдсөн байдаг.

Эдийн засгийн үндсэн мэдээнүүдийн ихэнх нь эдийн засаг хэр хөгжиж байгаа тухай мэдээнээс эхэлдэг. Эдийн засагт гарч буй өөрчлөлтүүдийг эдийн засгийн үзүүлэлтээр хэмждэг.

Эдийн засгийн үндсэн мэдээнүүдийн ихэнх нь эдийн засаг хэр хөгжиж байгаа тухай мэдээнээс эхэлдэг. Эдийн засагт гарч буй өөрчлөлтүүдийг эдийн засгийн үзүүлэлтээр хэмждэг.

## Үзүүлэлтүүд

Эдийн засгийн хөгжлийн судасны лугшилтыг амархан мэдэх арга болгож бүх засгийн газрууд эдийн засгийн үзүүлэлтүүдээ гаргадаг. Эдгээр үзүүлэлтийг хөрөнгө оруулалт, худалдаа, төлөвлөлт, аж үйлдвэрийн яам гэх мэт засгийн газрын байгууллагууд, статистикийн ерөнхий газар, эсвэл төв банкнаас гаргадаг. Эдгээр байгууллагуудад улс орны хэмжээний эдийн засгийн мэдээлэл цуглуулж, задлан шинжлэх үүрэгтэй мэргэжлийн эдийн засагчид

ажиллаж байдаг. Түүнчлэн, ерөнхийлөгч, ерөнхий сайд, төв банкны захирал, эсвэл сайд гэх мэт өндөр албан тушаалтнуудаас улс орны эдийн засгийн байдлын талаар мэдэгдэл хийхийг хүсч, эдийн засгийн цаашдын чиг хандлагын талаар урьдчилсан таамаглал дэвшүүлж болно.

Засгийн газрууд гадаад улс орон, гадаадын байгууллагаас техникийн туслалцаа авах нь олон байдаг. Хэрвээ тухайн оронд ажиллаж буй ямар нэг гадаадын эдийн засагч байдаг бол тэд иймэрхүү зээл тусламжийн талаар болон учир шалтгааных нь талаар мэдээлэл өгч чадах учраас тэдэнтэй уулзаж зөвлөх нь зүйтэй.

Энгийн харьцуулалт хийх нь хангалтгүй байж болох бөгөөд заримдаа чухал нарийн зүйлсийг орхигдуулж болно.

Хамгийн нийтлэг үзүүлэлтүүд гэвэл:

- Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ): Аливаа оронд тухайн өгөгдсөн хугацаанд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүн, үйлчилгээ.
- Үндэсний нийт бүтээгдэхүүн (ҮНБ): Тухайн улсын иргэдийн эх орондоо болон гадаадад үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Хэрэглээний үнийн индекс: Годорхой хугацаанд жирийн нэг өрхийн хэрэглэж буй сагсанд багтсан бараануудын үнийн хэмжүүр
- Үйлдвэрлэгчийн үнийн индекс: Үйлдвэрлэгчдийн эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэхдээ хэрэглэж байгаа сагсанд багтсан бараа бүтээгдэхүүний үнийн хэмжүүр
- Худалдааны тоо баримтууд: Экспорт, импорт гэх мэт үйл ажиллагааны тухай тоон үзүүлэлт, худалдааны болон урсгал дансны тэнцэл



- Ажил эрхлэлттэй холбоотой тоо баримтууд: Энэ нь тодорхой өгөгдсөн хугацаанд бий болсон буюу хорогдсон ажлын байрны тоо, ажилгүйчүүдийн тоо байж болно. Үүнтэй холбогдуулан ихэвчлэн хэрэглэдэг тоон харьцаа бол ажилгүйчүүдийн тоог нийт ажиллах хүчний тоонд харьцуулан хэмждэг ажилгүйдлийн хувь хэмжээ юм.

Эдгээр тоон үзүүлэлтийг сар, улирлаар гаргадаг бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийг гарах үед нь, эсвэл бүр гарахаас нь өмнө эдийн засагчид ямар хүлээлттэй байгааг судлах, боломжтой үед урьдчилан мэдээлэх нь чухал ач холбогдолтой.

Эдгээр үзүүлэлтийн талаар бичихдээ анхаарвал зохих цөөн хэдэн зүйл байдаг:

- Тухайн үеийн тоо баримтыг урд жилийн тоотой төдийгүй өмнөх хугацааны үеийн тоотой ямагт харьцуулж бай. Хэрвээ тухайн мэдээ 2 дугаар улирлын ДНБ-ний тухай бол түүнийг түрүү жилийн 2 дугаар улирлын ДНБ-тэй, бас мөн оны 1 дүгээр улирлын ДНБ-тэй харьцуулах ёстой гэсэн үг.
- Энгийн нэг харьцуулалт хийх нь хангалтгүй байж болох бөгөөд заримдаа чухал нарийн зүйлсийг орхигдуулж болно. Тухайн улсын ДНБ өсч байгаа мэт харагдахгүй байж болно. Гэхдээ, нийт дүнгээс харагдахгүй ч тухайн эдийн засгийн янз бүрийн салбаруудад чухал өөрчлөлтүүд гарч байж болно. Жишээлбэл, экспортын хэмжээ буурснаас хэрэглээний зарцуулалтад томоохон өсөлт гарсан байж болно, энэ нь ДНБ-ийг бүрдүүлж байгаа хэсгүүдэд нилээд өөрчлөлт гарсныг эс тооцвол ДНБ-ний нийт түвшинг тогтвортой байлгах болно.
- Улирлын чанартай өөрчлөлтүүдийг анхаарч, уншигчдад энэ талаар ойлгуул. Энэ нь цаг хугацааны нэг үеийг нөгөөтэй харьцуулах үед ихэвчлэн үүсдэг (Тухайн жилийн нэг сарын үзүүлэлтийг өмнөх оны мөн сартай харьцуулж жилийн өөрчлөлтийг гаргахад улирлын чанарын тухай асуудал гардаггүй). Жишээ нь, Вьетнамд ихэнх хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг Цагаан сарын баяраас нэг долоо хоногийн өмнө татаж авчирдаг учраас энэ үед хэрэглээний зарцуулалт, үнэ өсдөг. Энд үед авсан үзүүлэлт жилийн бүхий л хугацаанаас онцлогтой байдаг.
- Эдгээр тоо баримтыг ямагт тухайн нөхцөл байдал дээр нь буулгаж үзэж бай. Эдгээр үзүүлэлт нь саяхан болсон үйл явдлуудтай харьцуулахад ямар байна вэ? Эдгээр тоон үзүүлэлт нь ямар нэг чиг хандлагыг нотолж байна уу эсвэл хүлээгдэж байсан хандлагаас зөрж байна уу? Хэрвээ зөрж байгаа бол шинэ чиг хандлага эхэлж байна гэж үзэх үү, эсвэл эдгээр тоо нь хэвийн бус үзэгдэл үү? Мөн эдгээр тоон үзүүлэлт нь бусад бодлогуудын хувьд ямар агуулгатай буухыг бодож үзэхийг хичээх хэрэгтэй: Инфляцийн түвшин өндөр байх нь төв банкны нөөцийг өсгөх

магадлалтай юу? Юу өсөх вэ? Хүүгийн хувь хэмжээ юу? Засгийн газрын төсвийн орлого муу байх нь татварын шинэ багцыг нэвтрүүлэх магадлалтай гэсэн үг үү?

- Ижил төрлийн тоо баримтуудыг харьцуулж үз. ДНБ-ний үзүүлэлтэд засвар өөрчлөлт орох нь олонтаа гардаг, тэгвэл энэ үзүүлэлт урьдчилсан тоо юу, засварлагдсан тоо юу гэдгийг шалгаж, жилийн өмнөх болон өмнөх тайлангийн үеийн (ихэвчлэн хамгийн сүүлийн улирлын) урьдчилсан болон засварлагдсан тоон үзүүлэлттэй харьцуул.
- Хамгийн сүүлийн болон тухайн үеийн хоорондох хугацаанд хэмжүүрүүд өөрчлөгдсөн эсэхийг олж мэд. Жишээ нь, хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-г сагсан дахь бараа, бүтээгдэхүүний үнээр хэмждэг. Хэрвээ уг сагсанд ихэвчлэн хүнсний зүйл байгаа бол яг ийм сагсыг жилийн өмнө ашиглаж байсан эсэхийг шалгах нь чухал.
- Тухайн үзүүлэлтүүд чухам юу болохыг тодорхойлж, энэ тоон үзүүлэлтэд юу юу орсон талаар уншигчдад бага зэрэг мэдээлэл өгөх хэрэгтэй. Жишээ нь, ХҮИ-ийн талаар бичихдээ хэрэглээний үнийн индекс гэж юу болохыг тодорхойлж, уг индексийг хэмжиж байгаа бараа бүтээгдэхүүний сагсад орж буй зарим зүйлсийг дурдаарай.

## Кейс судалгаа

### Тайландын сам хорхойд дампингийн эсрэг тариф тогтоохгүй байхыг ноён Ватана АНУ-аас шаардаж байна

Ирэх долоо хоногт гарах журмаас урьтсан хүчин чармайлт

Фусадий Арунмас

(Bangkok Post-оос авсан ишлэл, 2004 оны 7 сарын 22)

Тайландын сам хорхойд ноогдуулах АНУ-ын дампингийн эсрэг тарифаас зайлсхийх эцсийн боломжит оролдлого болгож Худалдааны сайд Ватана Муангсүк Бушийн засгийн газарт хандан хоёр орны хоорондын урт хугацааны, ойр дотно харилцааг дурдан, “шударга, ахан дүүсийн хандлага”-аар хандахыг уриаллаа.

“Солонгост ч, Вьетнамд ч, бүр Ойрхи Дорнодын дайнд хүртэл бид АНУ-тай сайн нөхрийн хувьд олон жил мөр зэрэгцэн зогсоор ирсэн” гэж Ватана хэлээд “Энэ бол нийт Тайчуудын тээж явдаг сэтгэгдэл бөгөөд ирэх долоо хоногт Тайландын сам хорхойд ноогдуулах дампингийн эсрэг тариф тогтоох шийдвэр гаргахдаа АНУ-ын засгийн газар бидэнд сайн нөхрийн үүднээс хандана гэдэгт бид (Тайчууд) итгэж байна” гэлээ.

Ноён Ватанагийн үзэж байгаагаар хэрвээ Бушийн засгийн газар АНУ-ын сам хорхойчдыг дэмжсэн тогтоол гаргаж, Тай сам хорхойнд дампингийн эсрэг жинтэй тариф тогтоох юм бол, Тайчууд үүнийг урван тэрсэлсэнд тооцож, хоёр орны хооронд олон жилийн турш хөгжүүлсэн ойр дотно дипломат харилцаандаа “итгэл алдрах” юм байна.

Өндөр тариф тогтоох шийдвэр гаргавал Тайландын эрэг орчмын олон мянган сам хорхойн аж ахуй, сам хорхой боловсруулах үйлдвэрүүдийн мянга, мянган ажилчдын амьжиргаанд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй АНУ-ын сам хорхой хэрэглэгчдэд өндөр зардалтай тусах болно гэж тэрээр хэллээ.

Ноён Ватанагийн хүсэлт нь энэ сарын эхээр Вашингтоноос гаргасан анхан шатны тогтоолоос үүдэлтэй бөгөөд үүнд АНУ-д зах зээлийн үнээс доогуур үнээр сам хорхой нийлүүлсэн дампингийн хэрэгт Хятад,

Энэ мэдээнд анхаарвал зохих хэд хэдэн чухал элемент орсон байгаа:

- Энд дотоодын эдийн засгийн талаарх олон улсын худалдааны тохиролцоо, эс тохиролцооны талаар тайлбарлаж байна.
- Авч үзэж буй салбарыг тухайн нөхцөл байдал дээр буулгаж, улс орны эдийн засагт үзүүлэх ач холбогдлыг нь тайлбарлаж байна.
- Янз бүрийн эх сурвалжууд, түүний дотор сүүлийн үеийн номноос иш татаж байна.
- Тухайн орны нөхцөл байдлыг хөрш орнуудтай харьцуулж байна.
- Дундаж уншигчид ойлгомжтой үг хэллэгтэй байна.

Вьетнам улсуудыг буруутгаад байгаа билээ.

АНУ үүнтэй төстэй татварыг Тайландаас гадна Бразил, Эквадор, Энэтхэг зэрэг бусад гурван оронд ногдуулж байгаагаа ирэх Лхагва гаригт зарлахаар төлөвлөж байна.

Бусад орнуудад ногдуулахаар санал болгосон татварын хэмжээ харилцан адилгүй байгаа бөгөөд Хятадад 7.6%-112%, Вьетнамд 12.11%-93.13% байхаар тогтоожээ.

“Энэ хэрэгт АНУ-ын засгийн газар онцгой байдлаар хандахыг бид уриалмаар байна. Энэ тогтоол бол нийт Тайчуудын сэтгэл санаанд маш эмзэг асуудал юм, тиймээс одоогийн Бүгд Найрамдах намын засгийн газраас түрүүчийн Ардчилсан намын засгийн газар шиг Тайландад буруугаар хандахгүй байх гэдэгт би итгэж байна. Энэ тухай өмнөх Ерөнхийлөгч Билл Клинтон эдийн засгийн хямралын үеэр АНУ нь Тайландад хэрхэн хандаж байсанд харамсаж байгаагаа өөрийн дурдатгалуудад өчсөн байдаг”.

Ноён Ватанагийн хэлж байгаагаар Таксины засгийн газар АНУ-ын өндөр албан тушаалтнуудтай хэд хэдэн удаа яриа хэлэлцээр хийх замаар Тайландын сам хорхойг ихэвчлэн аж ахуйн аргаар боловсруулдаг, Тайландын сам хорхойчдын технологи бол АНУ-ын далайн сам хорхойчдынхоос илүү үр ашигтай гэдгийг тайлбарлахыг хичээсэн байна.

## **Учир шалтгааныг ойлгох нь**

Бид эдийн засгийн өсөлт, бууралтын шинж тэмдгүүдийг судалж үзлээ, одоо зарим учир шалтгааныг нь авч үзье. Аливаа эдийн засгийг өсөх буюу доройтоход хүргэж болох олон янзын бодлогууд болон үйл явдлууд байдаг. Хялбарчлах үүднээс тэдгээрийг хоёр хэсэгт хувааж үзье:

### **I. Эдийн засгийн гадна явагддаг зүйлс**

Эдийн засагчид эдгээр хүчин зүйлийг “гадны хүчин зүйлс” гэж нэрлэдэг. Эдгээр хүчин зүйлс нь аливаа улс орон хянаж чадахгүй ч эдийн засагт нь чухал нөлөөтэй байж болох үйл явдлууд юм.

- **Бараа, түүхий эдийн өөрчлөлт.** Хэрэв нефтийн үнэ өсвөл импортоор оруулж байгаа нефтийн үнэ нэмэгдэж, улс орны хэмжээний эрчим хүчний зардалд нөлөөлөх болно. Тээврийн зардал ч улам үнэтэй болж, улмаар үйлдвэрлэл явуулах өртөг зардал нэмэгдэнэ. Эдгээр үнийн өсөлтөөс улсын хэмжээгээр инфляци нэмэгдэхэд хүргэж мэднэ.
- **Хөрш орнуудын эдийн засгийн уналт.** Хэрвээ аль нэг хөрш орон нь зогсонги байдал буюу эдийн засгийн ухралтад орвол тухайн бүс нутгийн бусад орнуудад сөргөөр нөлөөлөх магадлал хамгийн их байдаг. Нэг хөрш улс нь хүндрэл бэрхшээлтэй байвал магадгүй тэр улс бусад улс орнуудаас бараа, бүтээгдэхүүн худалдаж авах нь багасна. Энэ нь эдгээр орнуудын экспортын орлогод сөрөг нөлөө үзүүлэх болно. Өнөөгийн дэлхий нийтийн эдийн засаг иймэрхүү харилцан хамаарал ихтэй болсон учраас бүр алслагдмал улс орны эдийн засгийн нөхцөл байдал ч олон орны эдийн засагт нөлөө үзүүлж болох юм.
- **Бусад газрууд дах хямрал.** Хөгжиж байгаа орнууд бусад хөгжиж байгаа улс орны буюу шинээр үүсч байгаа зах зээлд гарсан хямралт байдалд туйлын эмзэг өртөмтгий байдаг. Үнэхээр хүчтэй гэж болохоор эдийн засагтай улс байсан ч өөр нэг оронд гарсан хямралын байдал нь хөрөнгө оруулагчдыг бусад орнуудад хөрөнгө оруулах нь хэт эрсдэлтэй гэж үзэхэд хүргэж болох юм. Үүний үр дүнд хөрөнгө оруулагчид эдгээр орнуудад зээл өгөх нь илүү эрсдэлтэй гэж санаа зовсны улмаас гадаадын хөрөнгө оруулалт буурч, хүүгийн хувь өсч болно. Жишээлбэл, 1997 оны Азийн хямралын дараа дэлхий даяараа шинээр төрөн гарсан зах зээлд олгох зээлийн хүүгийн хувь өссөн нь хямралд ороогүй байсан Аргентин, Бразил улсад хүндрэл учруулсан юм. Энэ нь компаниудын хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэх хөрөнгө мөнгө зээлэх, засгийн газрууд өр зээлээ төлж барагдуулахад үнэтэй тусах болно.
- **Олон улсын валютын ханш.** Улс орнууд үндэсний валютаа доллар, евро гэх мэт аль нэг олон улсын валюттай холбож ханш тогтоох хандлагатай

байдаг. Хэрэв олон улсын зах зээл дээр долларын ханш чангарч байвал доллартай холбосон валюттай улсын мөнгөний ханш мөн өснө гэсэн үг. Ингэснээр тус улсын бараа, бүтээгдэхүүн гадаадад улам үнэтэй болж, өрсөлдөх чадвар нь буураад зогсохгүй түүний экспорт, өсөлтөд сөргөөр нөлөөлөх болно.

- **Цаг агаар.** Бараа түүхий эд голлон экспортолдог, ургацын хэмжээ цаг агаараас хамааралтай байдаг орнуудад ган гачиг гэх мэт улирлын чанартай өөрчлөлт, үйл явдлууд нөлөөлж болно.

## 2. Эдийн засаг дахь дотоод хүчин зүйлс

- **Төсвийн бодлого.** Засгийн газрын төсвийн бодлого, түүний дотор засгийн газраас татварын хэлбэрээр хэдий хэр мөнгө хуримтлуулж, энэ мөнгөө яаж зарцуулах тухай шийдвэрүүд.
- **Татварын бодлого.** Сэтгүүлчид татварын бодлогын (төсвийн бодлогын нэг хэсэг) олон талыг, тухайлбал ямар төрлийн бараа бүтээгдэхүүнд болон хэнд татвар ногдуулах тухай мэдээлдэг. Татвар нь сэтгүүлч хүн онцлон тэмдэглэх ёстой шууд бус чухал үр нөлөөтэй байдаг. Тамхины татвар хүмүүсийн тамхи татах явдлыг багасгах болно. Засгийн газраас тансаг хэрэглээний бараанд эсвэл эм тариа, хүнсэнд татвар ногдуулахаар шийдэж болно. Мөн тухайн оронд байгаа хамгийн баян чинээлэг хүмүүст татвар ногдуулах эсэх талаар шийдвэр гаргаж болно. Энэ бүх шийдвэр нь сурвалжлагч нарын хувьд чухал мэдээ байдаг.
- **Алдагдал.** Засгийн газрууд татвар болон бусад орлогоосоо илүү ихийг зарцуулах нь олонтаа байдгаас алдагдал үүсдэг. Ингэснээр тухайн засгийн газар алдагдлаа нөхөхийн тулд зардлаа багасгах, татвараа нэмэгдүүлэх эсвэл мөнгө зээлэх эсэхээ шийдэх шаардлагатай болно. Гэвч алдагдал бол ямагт муу зүйл биш байдаг. Энэ нь мөнгийг хэрхэн зарцуулж байна, ирээдүйд олох орлогоосоо өнөөдрийн өрөө эргүүлж төлж чадах эсэхээс хамаарна. Жишээлбэл, хэрвээ нэг засгийн газар мөнгө зээлж улмаар зам барих, ажлын байр бий болгох, сургуулиудыг засч сайжруулахад зарцуулсан бол үүнээс үүдэх эдийн засгийн өсөлт нь татварын шинэ орлогууд бий болгож улмаар зарцуулалтаа нөхөж болно. Гэвч ийм төрлийн зарцуулалт тун ховор байдаг: засгийн газрууд ихэвчлэн батлан хамгаалах зардлаа бууруулах эсвэл улс төрийн шалтгаанаар баячуудад илүү татвар ногдуулахыг хүсдэггүй учраас байнга алдагдалтай ажиллах нь илүүтэй байдаг. Мөн алдагдал бол асар их өр хуримтлагдсаны үр дүн байх нь олонтаа. Аливаа засгийн газар голцуу өмнөх засгийн газрын алдагдлыг үе залгамжлан авдаг бөгөөд энэ өрийн хүүг төлөхөд нилээд мөнгө зарцуулах шаардлагатай болдог. Өр зээлийн хүүг төлөх асуудал өндөр өртөгтэй тусах нь олонтаа бөгөөд дангаараа

хамгийн их зардлын зүйл анги болох нь хялбархан байдаг. Үүний нэг онцгой жишээ бол Ямаик улс бөгөөд тус улсын өр дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийхээ 170 хувьд хүрч, улсынхаа татварын орлогын нийт дүнгээс хэтэрсэн хэмжээний мөнгийг өр зээлийнхээ хүүд төлж байна.

- **Мөнгөний бодлого.** Энэ бол засгийн газраас эдийн засгийг хянах өөр нэг хэрэгсэл юм. Эдийн засагт хэр их мөнгө эргэлдэж байгааг тодорхойлох замаар засгийн газар эдийн засгийн өсөлтийн хурдыг өөрчилж болдог. Тухайлбал, олон оронд засгийн газрууд зүгээр л мөнгөн дэвсгэрт нэмж хэвлэх замаар эдийн засгийн хүндрэл бэрхшээлээ шийдэх гэж оролдож байв. Энэ нь ямагт инфляцид хүргэж, худалдаа ба санхүүгийн бусад хүндрэл бэрхшээлүүдийг үүсгэдэг байна. Мөнгөний бодлогыг ихэвчлэн аливаа орны төв банкнаас тодорхойлдог учраас тэндхийн ажилтнууд сурвалжлагч нарын хувьд чухал эх сурвалж байдаг.
- **Инфляци.** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өртгийг хэрэглээний үнийн индекс, үйлдвэрлэлийн үнийн индекс гэх мэт үзүүлэлтээр хэмждэг. Инфляцид нөлөөлдөг хэд хэдэн хүчин зүйлс бий. Эдийн засгийн суурь онолд инфляцийг эрэлт, нийлүүлэлт тодорхойлдог гэж үздэг. Хэрвээ аливаа эдийн засагт их хэмжээний мөнгө, цөөн тооны бараа бүтээгдэхүүн байвал бараа бүтээгдэхүүний үнэ өсөх ёстой. Иймээс, хэрвээ бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдэх эсвэл мөнгөний нийлүүлэлтийг багасгахад инфляци буурч болно. Импортын барааны үнийн өсөлт (нийтлэг жишээ гэвэл нефть) гэх мэт гадны нөлөөтэй үнийн өсөлт, эсвэл цаг агаартай холбоотой хүнсний хомсдол үнийг хөөрөгдөж болно. Түүнчлэн өндөр татвар тогтоох эсвэл ахуйн хэрэглээний үнийг өсгөх зэрэг засгийн газрын бодлогууд ч бүгд инфляцийн хувь өсөхөд нөлөөлж болно.

Заримдаа гадаад ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг болон тухайн эдийн засгийн дотоодод ямар өөрчлөлт хөгжил явагдаж байгааг мэдэхэд хэцүү байдаг. Засгийн газрууд үнэн хэрэгтээ өөрсдийн хариуцлагаас болж үүссэн хүндрэл бэрхшээлд гадаад хүчин зүйлсийг буруутгах дуртай байх нь олонтаа. Албан тушаалтнууд хүнсний хомсдолын шалтгаанаар цаг агаарыг буруутгах нь нийтлэг сонсогддог бөгөөд үнэн хэрэгтээ ган гачиг болон ургац муутай байх нь хүнсний зүйл хангалттай бус байгаа шалтгааны нэг л хэсэг байж болно. Энэ асуудлын нэг томоохон шалтгаан нь хураалт, тээвэрлэлт, түгээлт ч байж болох юм.

Эдгээр сэдвээр бичихдээ анхаарвал зохих нэг чухал зүйл бол янз бүрийн хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байна, тэдний талаар ямар нэгэн юм хийх боломжтой эсэх тухай асуудал юм.



## **ТУСГАЙ СЭДЭВ: Эргэж төлөгдөөгүй зээл**

Мөнгө зээлүүлэх нь түүнийг буцааж авахаас илүү хялбар байдаг бөгөөд банкныхан мөнгө зээлдүүлэхдээ зээлдэгч нь зээлийн чадвартай эсэхийг мэдэхгүй байх нь элбэг. Үүнээс болж зээл төлөгдөхгүй байх эсвэл хугацаа нь хэтэрч төлөгдөх явдал олонтоо гардаг. Эдгээр төрлийн найдваргүй зээлийг эргэж төлөгдөөгүй зээл гэдэг.

Хөгжиж байгаа орнуудад банкны зохицуулалт сул, банктай холбоотой хүндрэлтэй асуудлууд нийтлэг байдаг. Найдваргүй зээл нь голдуу банкны менежерүүд найз нөхөд, хамаатан садандаа зүй бусаар зээл өгч, тэдгээр нь эргүүлж төлдөггүйгээс болдог. Бусад тохиолдолд, төрийн өмчийн банкууд алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчийн үйлдвэрийн газруудад зээл өгч, тэдгээр нь уг зээлийг засгийн газрын татаас мэт үзэн эргүүлж төлдөггүй. Хүүгийн хувь өссөнөөр өмнө зээлсэн зээлийн хүүг хамаагүй өндөр болгож, улмаар хүүгийн хувь огцом өсөхөд эргэж төлөгдөөгүй зээлийн түвшин ч дагаж өсөх нь олон байдаг.

Эргэж төлөгдөөгүй зээл нь банкны ашигт ажиллагааг алдагдуулдаг бөгөөд үүнээс болж Швейцарийн Базел дахь Олон улсын Зохицуулалтын Банкнаас найдваргүй болж буй зээлийн санг нөхөхийн тулд банкуудад авч үлдэх шаардлагатай нөөцийн тухай олон улсын зохицуулалт гаргасан байна. Асуудал хэтэрхий хүнд болоод ирэх үед (1997-1998 оны үед Азид болсон шиг) засгийн газрууд оролцож, банкуудыг аврахыг оролдох нь олонтаа бөгөөд Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сангаас зээл авах явдал олон тохиолддог.

Иймээс сурвалжлагч нар зээлийн түвшинг ажиглаж, нийт олгосон зээлийн хэдэн хувь нь эргэж төлөгдөөгүй байгааг олж харах нь чухал. Ард түмэн банкинд итгэл алдрах байдал үүсгэхийг төв банк нь хүсдэггүй учраас эдгээр тоог нууцлах явдал нийтлэг ажиглагддаг. Гэхдээ энэ тоо нийтлэгдсэн ч банкууд хааяа найдваргүй зээлийг бүртгэх баттай бус аргыг ашигладаг учраас зээлийн тоо баримтын үнэн зөв эсэх нь эргэлзээтэй байдаг. Бусад тохиолдолд, банкууд бүртгэл муу хөтлөх, мөн найдваргүй зээлийн түвшинг тэр бүр мэдэхгүй байх явдал бий.

## Банкны үйл ажиллагааны тухай хэдэн үг

Эдийн засагчид, банк нь эдийн засаг дах мөнгийг үе үе татан төвлөрүүлж, эдийн засгийг ажиллуулж өгдөг учраас банкны систем бол улс орны эдийн засгийн зүрх нь гэж ярьдаг. Банк бол хүмүүс, компаниуд мөнгөө зөвхөн хадгалж болдог газар төдий биш юм. Банкууд шинэ тоног төхөөрөмж худалдан авахад эсвэл үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд хөрөнгө оруулахыг хүссэн компаниудад мөнгө зээлдэг, ингэснээр эдийн засгийн өсөлтөд тусалдаг. Хөгжиж байгаа орнуудад бизнесийнхэнд хэрэгцээтэй байгаа ихэнх мөнгийг банкууд олгодог.

Банкны систем нь эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг учраас сурвалжлагчид түүнд анхаарлаа хандуулж, хэр сайн ажиллаж

байгааг нь ажиглах хэрэгтэй. Мөнгөө банкинд хадгалсан хүмүүс, компаниудад банкууд хүү төлдөг. Түүнчлэн банкууд хадгаламж эзэмшигчдэд төлж байгаа хүүнээсээ өндөр хүүтэйгээр мөнгө гадагш зээлдүүлдэг. Банкны хадгаламж эзэмшигчдэд төлж байгаа мөнгө ба зээл авч байгаа хүмүүсээс авч буй шимтгэл хоёрын зөрүүгээр банк орлого олж байдаг. Мөн зарим банк үнэт цаас, бонд, гадаад валют арилжих замаар мөнгө олдог. Хөрөнгө оруулалтын банкууд компаниудад үнэт цаас, бонд гаргахад нь туслан шимтгэл авах, компаниуд нэгдэх, бие биеэ худалдан авахад туслах замаар бас орлого олдог. Гэвч хөгжиж байгаа орнуудын хувьд энэ бол орлогын гол эх үүсвэр биш юм.



# 4 Бараа түүхий эдийн тухай мэдээлэх нь

**Аня Шиффрин**

**Х**өгжиж байгаа олон орон бараа түүхий эд үйлдвэрлэдэг. Эдгээр нь кофе, будаа, буудай, какао, бензин, ашигт малтмал, мод, дал модны тос, резин, элсэн чихэр, шар буурцаг, жимс, ногоо гэх мэт түүхий эд байдаг. Ихэнх хөгжиж байгаа оронд хүн амын дийлэнх хэсэг нь фермерийн аж ахуй, уурхай, загас агнуурын газар ажиллаж эдгээр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийн зэрэгцээ худалдан авах, боловсруулах, дахин борлуулахад олон хүн оролцож байдаг. Эдгээр бүтээгдэхүүнийг ихэвчлэн экспортлож, голдуу Америк, Европт гаргадаг боловч үйлдвэрлэгчдийн хувьд энэ үйл явцаас тэгтэл их мөнгө олдоггүй. Жишээлбэл, Африк тив дэлхийн очир алмас, алт, какао, дал модны тосны ихэнхийг үйлдвэрлэдэг. Гэсэн ч Африк тив дэлхийн аль ч бүс нутгаас хамгийн олон тооны ядуу буурай орнуудтай байдаг.

## Энэ бүлэгт:

- Бараа түүхий эдийг хэрхэн худалдаалдаг тухай
- Мэдээний санаа оноо
- Зах зээлийн мэдээ бичих тухай
- Нөөц баялгийн сөрөг үр дагавар
- Кейс судалгаа зэрэг асуудлууд хамрагдсан .

## Ерөнхий дүр зураг

Бараа түүхий эд үйлдвэрлэдэг орнууд энэ ажлаа ихэвчлэн зуу зуун жилээр эрхэлсэн байдаг, эдийн засагчид үүнийг энэ салбарын харьцангуй давуу тал гэж хэлэх байх. Харьцангуй давуу тал гэдэг нь улс орнууд өөртөө байгалиас заяасан онцлог бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг гэсэн үг. Жишээлбэл, их хэмжээний фермерийн газартай, хямд ажиллах хүчтэй улс орнууд компьютер, программ хангамж хийхээсээ будаа тарьсан нь илүү ач холбогдолтой гэж үздэг. Ийм учраас, Дэлхийн банк гэх мэт гадаадын зөвлөхүүд бараа түүхий эд үйлдвэрлэдэг орнууд гангийн үйлдвэр, автомашины үйлдвэр, аж үйлдэрийг хөгжүүлж, авч явахад өртөг ихтэй салбарт хөрөнгө оруулж байснаас бараа түүхий эдээ үйлдвэрлэж байсан нь

дээр гэдгийг зөвлөмж болгосоор иржээ. Онолын үүднээс бараа түүхий эд үйлдвэрлэхийн бас нэг давуу тал бол энэ нь холбогдох бизнесүүдэд түлхэц болж чаддагт оршино. Жишээлбэл, жимс тарьж ургуулдаг улс жимсний чанамал, шүүс үйлдвэрлэж, улмаар савлах лаазлах үйлдвэр байгуулж болно. Энэ нь ажлын байр шинээр бий болгож, ур чадвар, технологийн түвшинг дээшлүүлээд зогсохгүй эдийн засаг өсч хөгжихөд ч тустай.

Харамсалтай нь, хөгжиж байгаа орнуудын хувьд бараа түүхий эдийн үнэ буурах хандлагатай, “наад захын үйл ажиллагаа” болдог учраас түүнийг үйлдвэрлэхэд оролцож байгаа хүмүүс их хэмжээний баялаг бий болгож чадахгүй гэсэн үг. Бараа түүхий эд ихээр үйлдвэрлэдэг орнууд дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэлд эмзэг өртөмтгий байдаг. Дэлхийн зах зээлийн үнэ буурснаар тухайн улс бага орлого олж эхлэх учраас хүнд байдалд орж, засгийн газрууд нь зарцуулалтаа багасгах шаардлагатай болж, тэр ч байтугай хэрэв гадаад өр зээлтэй бол түүнийгээ эргүүлэн төлж чадахгүйд хүрдэг.

Бараа түүхий эд үйлдвэрлэгч орнуудын үнийг тогтвортой байлгах хамтын оролдлого ихэнхдээ амжилтгүй болж байлаа. Тухайлбал, 1997 оны Азийн хямралын үед резин үйлдвэрлэгчдийн холбооны гишүүд үнийг тогтворжуулахын тулд үйлдвэрлэлээ багасгаж чадаагүй бөгөөд энэ нь тэр жил гишүүн орнуудын фермерүүдийн хувьд мөнгө олох шаардлагатай холбоотой байлаа. Тэд үнэ эргээд өсөх байх гэж найдсанаас болж нийлүүлэлтээ багасгах эрсдэл хийж чадаагүй юм.

Бараа түүхий эдийн нийлүүлэлт нэмэгдэж байгаа сул талаас болоод Солонгос, Малайз гэх мэт орны засгийн газрууд бусад салбар, аж үйлдвэр хөгжүүлэх алхам хийгээд байна. Солонгос бол түүхий эд тарьж ургуулагч орноос цахилгаан бараа, технологи гэх мэт өөр чиглэлд амжилттай шилжсэн орны жишээ юм. Малайз гэхэд өмнө нь резин, дал модны тос ихээр үйлдвэрлэдэг байсан бол одоо ажилчид нь цахилгаан бараа угсрах болж, засгийн газар нь программ хангамжийн салбарт илүү их ажлын байр бий болгохоор хичээж байна. Дэлхийг бүхэлд нь хараад байхад хөгжилд хамгийн амжилттай хүрсэн орнууд бол үйлдвэрлэлийн гарцаа олон янз болгож, өөрчилж чадсан орнууд байдаг нь тодорхой байна.

Сурвалжлагч нарын хувьд анхаарвал зохих чухал асуултууд бол тухайн засгийн газар улс орныхоо үйлдвэрлэлийг шинэ салбарт чиглүүлэн өөрчлөхөөр төлөвлөж байгаа эсэх, эдгээр төлөвлөгөө нь амжилт олох магадлалтай эсэх тухай асуултууд юм. Бараа түүхий эдийн тухай мэдээлдэг сэтгүүлч тухайн засгийн газар хүнсний үйлдвэрлэл гэх мэт шинэ, илүү нарийн түвэгтэй технологийн салбарт шилжих төлөвлөгөөтэй эсэх, цаашдын хөгжлийг өөр салбаруудад чиглүүлэх төлөвлөгөөтэй эсэх талаар мэдэхийг хүсэх болно. Тэд мөн олон улсын худалдааны гэрээ хэлэлцээрүүд, фермерүүдэд өгч байгаа татаасын хэмжээнд сайтар ажиглалт хийхийг хүсэх

болно. Эдгээр татаас нь бараа түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийг унагаж, улмаар хөгжиж байгаа орнуудын фермерүүдийн олж байгаа мөнгөний хэмжээнд нөлөө үзүүлдэг. Түүнчлэн заримдаа хямд бараа түүхий эд хөгжиж байгаа орнууд руу экспортлогдож эдгээр орнуудын хэрэглэгч нарт ашиг тусаа өгч байгаа боловч ийм доогуур үнэтэй өрсөлдөж чадахгүй дотоодын фермерүүдэд хор хохирол учруулдаг.

### **Бараа түүхий эд хэрхэн худалдаалагддаг вэ**

Будаа, нефть гэх мэт бараа түүхий эдийг дахин борлуулах болон дахин түгээхээр төлөвлөж буй компаниуд, засгийн газрууд худалдан авах нь нийтлэг байдаг. Эдгээрийн зарим нь олон улсын томоохон пүүсүүд байдаг. Мөн иргэдийнхээ хүнс болон бусад барааны хангалтыг баталгаажуулахын тулд бараа, түүхий эд худалдан авдаг засгийн газрын агентлагууд ч байдаг. Жишээлбэл, Филиппин, Индонезид дотоодын хоол хүнсний нэг салшгүй чухал хэсэг нь будаа байдаг боловч дотоодын үйлдвэрлэл нь иргэдийн хэрэгцээг бүрэн хангаж чаддаггүй байна.

Ихэвчлэн зуучлагчид эсвэл худалдаачид бараа түүхий эдийг фермерүүдээс худалдан авч, тэдгээрийг боловсруулдаг, экспортолдог компаниудад худалддаг. Үүний тулд эдгээр зуучлагчид тухайн компаниуд болон засгийн газруудтай гэрээ байгуулдаг. Үнийг тогтвортой байлгахын тулд ихэнх гэрээг урьдчилж хийдэг. Жишээ нь, жүржийн шүүс хийдэг нэг компани тогтсон үнээр урьдчилж жүрж захиалснаар уг компани өөрийн худалдан авч чадах хэмжээний үнээр хангалттай нөөц бэлдэж авсандаа итгэлтэй байж чаддаг.

Дэлхий даяархи бараа түүхий эдийн зах эдгээр гэрээний худалдаа арилжаан дээр оршин тогтнодог. Хамгийн алдартай хоёр нь Чикаго ба Сингапурын зах байдаг. Чикагогийн Худалдааны Зөвлөл 1848 онд байгуулагдсан бөгөөд өнөөдөр эрдэнэ шиш, шар буурцаг, буудай, овъёос, алт, мөнгө болон бусад төрлийн бараа түүхий эдийн тэргүүлэх зах болоод байна. Сингапурын бараа, түүхий эдийн зах дээр резин, кофег дээрхээс арай бага боловч бас их хэмжээгээр худалдаалдаг. (Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [www.cbot.com](http://www.cbot.com), [www.sicom.com](http://www.sicom.com) сайтуудаас үзнэ үү)

### **Зах зээлийн мэдээ бичих нь**

Зах зээлийн бусад бүх мэдээний нэг адил биржийн мэдээ нь үнэ ямар байгаа, яаж өөрчлөгдөх хандлагатай байгаа болон хэн худалдан авч, хэн худалдан борлуулж байгаад голлон анхаардаг.

- Захын хаах үеийн ханш ямар байсан, энэ нь өмнөх өдрийн мөн үетэй харьцуулахад ямар байгааг ямагт мэдээлэх
- Нэг захын үнэ ханшийг нөгөө захынхтай болж өгвөл харьцуулж байх
- Захын үнэ ханшид өөрчлөлт үзүүлсэн гол үйл явдлуудыг дурдах
- Худалдагч ба худалдан авагчийн квотын тухай оруулах
- Үнэ ханш яаж өөрчлөгдөх таамаглалыг аль болох оруулж өгөх  
Захын ирээдүйн үнэ ханшийн тухай дурдах

### **Бараа түүхий эдийн тухай өдөр тутмын мэдээ**

Бараа түүхий эдийн талаар мэдээлдэг сурвалжлагч нар ургацын гарц, экспорт, импортын үнэ (бордоо, үр гэх мэтийн)-д нөлөөлөх хүчин зүйлсийн тухай болон юу худалдаалагдсан тухай бичдэг. Энэхүү бүх хүчин зүйлс нь хөгжиж байгаа орнуудын ард түмний амьжиргаанд нөлөөлж байдаг. Бараа түүхий эдийн тухай энгийн мэдээнүүдэд:

- Тодорхой нэг бараа түүхий эдийг ихээр эсвэл багаар үйлдвэрлэх төлөвлөгөө
- Тарьж ургуулж байгаа хөдөө аж ахуйн шинэ төрлийн бараа түүхий эд
- Ургацын байдлын тухай урьдчилсан таамаглал
- Цаг агаарын мэдээ
- Томоохон худалдан авагчдаас ямар захиалга хийхээр төлөвлөж байгаа тухай мэдээ
- Чикаго, Сингапурын гэх мэт дэлхийн гол гол захын худалдаа, ирээдүйд үнэ ханш ямар байх тухай
- Тариалангийн тухай
- Бордооны үнэ, импортын тухай
- Засгийн газрын бараа түүхий эдийн талаарх зохицуулалт
- Засгийн газрын үнэ тогтоох, үнийг дэмжих эсвэл татаас, зээл олгох төлөвлөгөө, юуг, хэзээ тариалах талаар зөвлөгөө өгөх, газар тариаланг өргөжүүлэх зэрэг фермерүүдэд үзүүлдэг үйлчилгээ, бусад тусламж
- Ургамлын өвчин, хортон шавьжийг эсэргүүцэх чадвартай, өндөр ашиг шимтэй тариалангийн шинэ хэлбэрүүдийг олж нээх гэх мэт шинжлэх

ухааны нээлт, ололтууд

- Патенттай холбоотой маргаан
- Шинэ тоног төхөөрөмжийн импорт эсвэл боловсруулах шинэ үйлдвэр байгуулах гэх мэт технологийн хөгжил
- Гадаадын хөрөнгө оруулалт
- Зам тээвэр, дэд бүтцийн тухай мэдээ (Эдгээр нь бараа түүхий эдийг түргэн хугацаанд экспортлоход нөлөөлдөг)
- Газрын шинэтгэлийн төлөвлөгөө
- Олон улсын худалдааны гэрээ гэх мэт засгийн газрын алс хэтийн бодлого
- Хувийн салбарт хийгдэх гадаадын худалдан авагч нарын эсвэл засгийн газруудын гол гол худалдан авалт

### **Нөөц баялгийн сөрөг үр дагавар**

Нефть, байгалийн хий, ашигт малтмал гэх мэт өндөр үнэ цэнэтэй бараа түүхий эд бүхий олон улс орнууд эдгээр нөөц баялаг байхгүй орнуудаас ч дор байх гаж үзэгдэл байдаг. Энэ нь хөгжиж байгаа оронд эдгээр нөөц баялгийг олборлож байгаа компаниуд ашгийг нь өөрсдөө аваад тухайн нөөц бүхий оронд маш бага хэсгийг буцааж өгдөг үндэстэн дамнасан корпорациуд байдагтай холбоотой. Энэ нь аж үйлдвэр хөгжсөн орнууд үйлдвэрлэлийн зардлын ихэнх хувийг авч, хөгжиж байгаа орнууд маш бага хувийг нь хүртдэг гэсэн үг. Маш цөөхөн тохиолдолд тухайлбал нефтийн салбарт, зарим орон эдгээр нөөц баялгийнхаа үйлдвэрлэл, хуваарилалтыг хянан удирдаж чаддаг учраас ашгаас нь их хэмжээний хувь хүртэх болсон байдаг.

# Кейс судалгаа

## Солонгос дахь сүйрлийн үе

Дональд Грийнлесс/ СӨҮЛ  
(Алс дорнодын эдийн засгийн тойм буюу the *Far Eastern Economic Review* сэтгүүлээс авсан ишлэл, 2004 оны 7 сарын 29)

2002-2003 оны өвөл термометрийн заалт урьд өмнө ховор тохиолддог доод хэмжээнд хүрч, дулаан, цахилгаанд зориулсан хийн эрэлт хэрэгцээ тэнгэрт тулсан үед Өмнөд Солонгосын байгалийн хийн салбарын албан тушаалтнууд нөөц нь багасч сэтгэл зовох хэмжээнд хүрснийг анзаарчээ. Шингэрүүлсэн байгалийн хий буюу ШБХ-н нөөц хомсдож эхэлмэгц цахилгаан эрчим хүчний компаниудыг эрчим хүч орлуулан гаргах түлшний өөр эх үүсвэр, хувилбарыг эрж хайхыг зөвлөсөн байна. “Нөхцөл байдал маш аюултай байлаа” гэж Солонгосын Хотуудын Хийн Холбооны тэргүүн Ёонг Хүн Ким хэлээд “Бид нуман тулгуурт бараг орсон. Манай дамжуулах байгууламжууд дөнгөж ганц, хоёр өдрийн нөөцтэй байлаа” гэлээ.

Солонгосын Хийн Корпораци буюу Когас энэ хэрэгцээг хангахын тулд бирж дээрээс тухайн үеийн үнээр карго буюу тээврийн ачаа худалдан авахаар сандралдав. Тэр жил Солонгос улс оршин суугчдын болон арилжааны хэрэгцээнд халаалт, хоол унд бэлтгэхэд зарцуулагдаж буй хийн урсгалын тогтвортой байдлыг хангахын тулд урьд өмнө байгаагүй их хэмжээгээр буюу 42 карго худалдан авчээ. “Тэр хэмжээнд хүрч хангахын тулд тэд маш их ажиллах шаардлагатай байсан” гэж барууны эрчим хүчний компанийн нэгэн ажилтан хэлсэн юм.

Тэрхүү амь өрсөн өвлөөс хойш Солонгосын засгийн газар, хийн салбарын

## Энэ мэдээнд анхаарвал зохих хэд хэдэн чухал бүрдэл орсон :

- Сонирхол татахуйц, ойлгомжтой эхний догол мөр буюу удиртгал орсон байна.
- Ирээдүйд чухал утга агуулгатай эдийн засгийн асуудлыг тайлбарлаж байна.
- Энэ асуудал эдийн засагт бүхэлд нь болон өөр өөр салбарт хэрхэн нөлөөлж болохыг дурджээ.
- Засгийн газрын эх сурвалж бус, илүү өргөн хүрээтэй төлвийг харуулсан эх сурвалжуудаас иш татсан байна.

ажилтнууд энэ байдлыг дахин давтагдуулахгүйн төлөө алхмууд хийсний дотор Малайз болон Австралитай дунд хугацаанд, зөвхөн өвлийн улиралд ШБХ нийлүүлэх хоёр гэрээ байгуулж, мөн 2012 он гэхэд нөөцийн багтаамжийг бараг хоёр дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Гэвч Японы дараа дэлхийд хоёрдугаарт ордог хамгийн том ШБХ импортлогч болох Өмнөд Солонгосын хийн аж үйлдвэрийн салбар амаргүй байдалд самгардсан хэвээр, ямар нэг тодорхой төлөвлөгөөгүй ажиллаж байна гэж шинжээчид, гүйцэтгэх ажилтнууд ярьж байна. Ирэх арван жилд Солонгос улс асар их ШБХ-н хомсдолтой тулгарах болно. Жилийн хийн эрэлт, нийлүүлэлтийн хоорондын зөрүү 2015 он гэхэд 17.5 сая тонноос 22.5 сая тонн хүрэх тооцоо гарч байна. Энэ нь бараг энэ жилийн хэрэглээний тооцоолсон хэмжээ буюу 21.5 сая тоннтой тэнцүү юм.

# 5 Бизнесийн ба эдийн засгийн мэдээ сурвалжлагад интернэтийг ашиглах нь

Жэйн М.Фолпе

**Б**изнес, эдийн засгийн талаар илүү ихийг мэдэхэд зориулсан хамгийн сайн хэрэгслүүдийн нэг нь Интернэт юм. Сурвалжлагч эндээс бизнесийн болон эдийн засгийн чиг хандлага, тэдгээрт хэн, юу нөлөөлж байгааг болон холбогдох байгууллага, хүмүүсийн талаар олж мэдэх боломжтой. Интернэт нь валютын хямралаас эхлээд бараа түүхий эд, компаниуд хүртэл бүхий л зүйлийн тухай хамгийн сүүлийн үеийн баримт, судалгаа шинжилгээгээр хангаж өгдөгөөрөө мэдээ сурвалжлагыг сайжруулахад тусалж чаддаг. Мөн энэ чиглэлээр дэлхийн өнцөг булан бүрт байгаа бусад сэтгүүлч юу бичиж байгааг ч харуулж чадна. Түүнчлэн, тодорхой тоон үзүүлэлт буюу эх материал хайж байгаа сурвалжлагч хүнд Интернэт туйлын ашиг тустай байж чадна.

Хэдийгээр Интернэт нь бизнес, эдийн засгийн мэдээ сурвалжлагыг сайжруулахад тусалж чадах боловч мэдээ сурвалжлагын уламжлалт аргуудыг орлох ёсгүй. Гадагшаа гарч хүмүүстэй биечлэн уулзаж ярилцах, ярилцлага авах, асуулт асуух нь чухал ач холбогдолтой хэвээр байна. Юу болж байгааг биеэр үзэж харах, тоо баримтын цаана болж байгаа юмс, үзэгдлүүдийг ойлгож мэдэхийн тулд мэдээнд дурдаж буй газрууддаа өөрөө очиж үзэх зайлшгүй шаардлагатай.

Онлайнаар суурь судалгаа хийж буй үедээ сайн сурвалжлагч шиг бодож сэтгэж, өөрөөр хэлбэл, шүүмжлэлтэй, дүн шинжилгээ хийх байдлаар хандаж бай. Их хэмжээний мэдээлэл бэлэн байгаа үед сайн, муу эх сурвалжуудыг хооронд нь хэрхэн ялгах мэддэг байх нь чухал. Тэгээд нэгэнт сайн эх сурвалжийн мэдээ болох нь тогтоогдвол, итгэж болох вэбсайт болох нь тогтоогдвол түүнд багтсан асуудлууд эсвэл нэг талыг хэт

## Энэ бүлэгт дараах Интернэт эх сурвалжуудыг оруулж байна:

- Ерөнхий мэдээлэл
- Засгийн газрын ба албаны эх сурвалжууд
- Олон улсын байгууллагууд
- Судалгааны институтууд
- Компаниуд
- Экспорт, худалдаа ба бараа түүхий эд
- Идэвхтэй бүлгүүд

барьсан зүйлийг авч үзэх нь чухал. Бүх эх сурвалж хичнээн найдвартай байхаас үл хамааран ямар нэг хэмжээгээр нэг талыг барьсан байдаг. Энд багтсан асуудал таны гарын дор буй мэдээлэлд хэрхэн нөлөөлөх вэ? Ямар нэг асуудал буюу хазайлтыг илрүүлэхийн тулд бүх эх сурвалжуудыг нарийн шалгаж тогтоосон байх шаардлагатай. Мөн нөгөө талыг нь ч бас оруулахаа битгий мартаарай.

Сурвалжлагчийн олонтаа гаргадаг нэг алдаа бол тухайн мэдээллийг цуглуулж, бичихийн тулд багагүй цаг зарсан учраас баттай гэж үзэх явдал байдаг. Эх сурвалжаасаа илүү баттай мэдээлэл гэж үгүй. Тэр тусмаа шалгаж нягтлах хэрэгтэй. Тухайн тоо баримт яг юу хэлэх гээд байна вэ, тэр нь утга учиртай юм уу гэдэг талаар сайтар бодож үз. Тухайн тоонуудыг ерөнхий сэдэвтэй нь ямар нэг хэмжээгээр уялдуулж уншигчдад ойлгомжтой, хүртээлтэй болго. Эцэст нь, газар дээрээс нь олж авсан мэдээллээ тухайн салбарын эрх бүхий этгээдээр шалгуулж нягталдаг шиг онлайнаар олсон бүх мэдээллээ шалгах хэрэгтэй.

Номын сангаас мэдээлэл эрж олох олон арга байдаг шиг Интернэт ашиглан хайлт хийх бас олон арга байдаг. Ямар нэг асуудлаар гарсан хэвлэлийн мэдээлэл төдийгүй улс төр, эдийн засгийн эх сурвалжид сурвалжлагчийг чиглүүлж өгдөг нэг цэг бол хайлтын системүүд байдаг. Дэлхийн өнцөг булан бүрт буй олон сурвалжлагчийн ашигладаг хамгийн сайн хайлтын системүүдийн нэг бол Google ([www.google.com](http://www.google.com)) байдаг. Бусад хайлтын систем гэвэл Yahoo!Search ([www.yahoo.com](http://www.yahoo.com)), WebCrawler ([www.webcrawler.com](http://www.webcrawler.com)), AltaVista ([www.altavista.com](http://www.altavista.com)) юм.

Энэ бүлэгт хайлт хийж их цаг алдалгүйгээр Интернэт ашиглан мэдээлэл олж авах өөр өөр арга замын тухай ярих болно. Гэхдээ, дор дурдсан жагсаалт бол сурвалжлагч олон улсын бизнес, эдийн засгийн талаар мэдээлэхэд зориулсан сая сая сайтуудын нэг хэсэг юм (шинэ сайтууд төрөн гарсаар байна). Аль ч талаар авч үзсэн энэ нь өргөн хүрээтэй байна эсвэл тодорхой хөтөч болно гэсэн үг биш.

### **Өөрийгөө мэдээллээр ханга**

Ихэнх сэтгүүлч, сурвалжлагч нар өөрийн мэргэжсэн чиглэлээр гол гол сонин, сэтгүүлийн төдийгүй телевиз, радиогийн мэдээг тоймлон авч үзэх байдлаар өдрийг эхэлдэг. Олон тохиолдолд Интернэт үүнийг хамаагүй хялбар болгоод байна. Бүс нутаг, улс орнууд ихэвчлэн өөрийн дотоодын телевиз, радиогийн нэвтрүүлэг, мөн түүнчлэн сонин, сэтгүүлтэй байдаг нь мэдээлэл авахад асар их тустай байж болно. Дэлхийн өнцөг булан бүрт буй хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээ мэдээлэлтэй танилцаж болох нэг сайн сайт бол [www.abyznewslinks.com](http://www.abyznewslinks.com) дээр байдаг Newspaper and News Media Guide буюу Сонин хэвлэл, мэдээний хэрэгсэлийн хөтөч мөн.

Мөн дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлыг болон зарим тохиолдолд тодорхой үйл явдлыг олон улсын сонин хэвлэлүүд хэрхэн мэдээлж байгааг



харах нь зүйтэй. Дэлхий дахины бизнес, эдийн засгийн чиг хандлагын тухай сайн мэдээ сурвалжлагууд дараахь сайтуудад байдаг:

- BBC [www.bbc.co.uk](http://www.bbc.co.uk)
- *BusinessWeek* буюу Бизнесийн долоо хоног сэтгүүл [www.businessweek.com](http://www.businessweek.com) : Энэ бол бизнесийн ерөнхий мэдээ, мэдээллийн маш сайн сайт.
- *The Economist* буюу Эдийн засагч сэтгүүл [www.economist.com](http://www.economist.com). Энд захиалгагүйгээр зарим нэг нийтлэлийг тавьдаг.
- *Financial Times* [www.ft.com](http://www.ft.com) (зөвхөн захиалгаар)
- Reuters [www.reuters.com](http://www.reuters.com)
- *The Wall Street Journal* [www.wsj.com](http://www.wsj.com) (зөвхөн захиалгаар)

Тухайн асуудлаар мэргэшсэн сурвалжлагчийн хувьд цаг үетэйгээ хөл нийлүүлж, тухайн газар нутагтаа санхүү, эдийн засаг, технологи эсвэл өмч хувьчлалын талаар юу болж байгааг сайтар мэдэж байх нь чухал. Тухайн салбарт шинэ сонин хэн, юу байна вэ? Энэ хүний эсвэл үйл явдлын тухайн салбарт үзүүлэх нөлөө ямар байна вэ? Засгийн газар, хөрөнгө оруулагчид үүнд яаж хандаж байна вэ? Шинжээч, эрдэмтэн судлаачид үүнийг хэрхэн анзаарч, ажиглаж байна вэ?

Эдгээр асуултын аль нэгэнд хариулт өгөхийн тулд эдийн засаг, санхүүгийн сэтгүүлүүд, технологийн ном хэвлэл, хэлэлцүүлгийн самбарууд, засгийн газрын вэб сайтууд, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан гэх мэт байгууллагуудын вэб сайтууд зэрэг салбарын эх сурвалжуудын тоймыг байнга үзэж, хайж бай.

Мэдээний санааг гаргах шилдэг аргуудын нэг бол сэдвийнхээ талаар байнга уншиж судалж байх явдал юм. Аливаа асуудлын тухай юу бичигдсэнийг эрж хайх биш, юу бичигдээгүй үлдсэн байгааг олж мэдэхээс илүү сайн арга гэж үгүй. Түүнчлэн, мэдээлэх гэж байгаа сэдвийнхээ талаар унших нь уг үйл явдал болж байгаа улс орныхоо улс төр, нийгэм, эдийн засгийн үндэс суурийг танин мэдэх сайн арга юм. (Хавсралт А-г үз)

### **Засгийн газрын буюу албан ёсны эх сурвалжууд**

Олон засгийн газар, ялангуяа АНУ, Европын Холбооны орнуудын засгийн газрууд улс орныхоо нийгэм, улс төр, эдийн засгийн тухай сонирхолтой мэдээллийг ихээр тавьсан байдаг. Энэ мэдээлэл нь мэдээ сурвалжлага бичихэд нэн ашиг тустай байж болох ч дандаа үнэн зөв эсвэл сүүлийн үеийн шинэ мэдээ биш байдаг учраас түүнд хэт найдаж болохгүй. Түүнчлэн ийм

Мэдээний санааг гаргах хамгийн шилдэг аргуудын нэг бол сэдвийнхээ талаар байнга уншиж судалж байх явдал юм.

мэдээлэл нь мэдээлж байгаа тухайн улс орны тодорхой ашиг сонирхлыг ямагт тусгасан байдгийг санаж байх нь чухал.

Чикаго дахь Нортвэстэрн Их Сургууль (Northwestern University) (<http://www.library.northwestern.edu/govpub/resource/internat/foreign.html>) гэсэн вэб сайт ажиллуулдаг нь засгийн газрын сайтууд болон дэлхий ертөнцтэй холбож өгдөг. Энэ сайт нь янз бүрийн яамд, газрууд, агентлагуудын вэб сайтуудаас гадна засгийн газар бүрт холбогдох статистик мэдээллийг хаанаас олж болохыг бас харуулдаг.

Европын Холбоо (<http://europa.eu.int>) ч албан ёсны вэб сайттай бөгөөд ЕХ-ны улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлуудын талаар мэдээллийг 11 хэлээр тавьдаг. Мөн бусад сэдвээс гадна Европын Холбооны орнуудын эдийн засгийн ба хүн ам зүйн албан ёсны мэдээлэлтэй <http://europa.eu.int/comm/eurostat> гэсэн хаягаар танилцаж болно.

АНУ-ын Төрийн Департамент (<http://www.state.gov/r/pa/ei/bgn>) сайт ажиллуулдаг, эндээс АНУ-ын ямар нэг байдлаар сонирхдог улс орнуудын тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах боломжтой.

АНУ-ын Тооллогын Товчоо (<http://www.census.gov/ftp/pub/foreign-trade/www/>) гэсэн хаягаар гадаад худалдааны статистик тоо баримт, урсгал тоон үзүүлэлт, экспортын мэдээллээс гадна АНУ-ын худалдааны алдагдлын тухай мэдээллээр хангадаг.

Элчин сайдын яамд, консулын газрууд хилийн чанадад аливаа орны нүүр царай болж ажилладаг бөгөөд улс төр, эдийн засгийн суурь мэдээлэл олж авах нэг найдвартай газар байж чаддаг. Дэлхий дахины хэмжээнд буй элчин сайдын яамд, консулын газруудын жагсаалтын хувьд <http://embassyworld.com> хаягаар хандана уу.

## **Олон улсын байгууллагууд**

Олонх олон улсын байгууллагууд судалгааны ажил, бусад хэвлэл нийтлэлүүдийг өөрсдийн вэб сайт дээр байрлуулдаг. Үүнээс цөөн хэдийг нь дурдъя:

Вашингтонд төвтэй Дэлхийн Банк нь хөгжиж байгаа орнуудад хөрөнгө, техникийн туслалцаа үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан бөгөөд дэлхий дахинд хийгдэж буй төсөл, хөтөлбөр, санаачлагуудын тухай мэдээллээр хангадаг. Тус банкны үндсэн сайт (<http://www.worldbank.org>) ба судалгааны хэлтсийн (<http://econ.worldbank.org>) сайтад орж холбогдох мэдээллийг авч болно. Түүнчлэн дэлхийн тодорхой нэг хэсгийн тухай мэдээллийг авахын тулд Америк хоорондын хөгжлийн банк (<http://www.iadb.org>), Азийн хөгжлийн банк (<http://www.adb.org>) гэх мэт бүс нутгийн хөгжлийн банкуудад хандаж болно.

Мөн хөгжиж байгаа орнууд санхүүгийн болон техникийн туслалцаа авахаар Олон Улсын Валютын Санд (<http://www.imf.org>) ханддаг. Тухайн нэг оронтой байгуулсан зээлийн гэрээнүүдийн тухай тодорхой мэдээлэл, мөн

дэлхийн эдийн засгийн чиг хандлагын тухай тайлангуудыг ОУВС-ийн вэб сайтаас олж болно. Дэлхийн улсуудын төв банкны тухай (<http://jolis.worldbankimflib.org/Special/annualre.htm>) гэсэн Дэлхийн банк, ОУВС-ийн хамтарсан онлайн эх сурвалж байдаг. Эдийн засгийн статистик мэдээлэл хайж байгаа сурвалжлагч аливаа орны төв банк, сангийн яамны мэдээллийг авахыг ямагт хичээх хэрэгтэй.

Швейцарийн Женевт төвтэй Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ) дэлхий нийтийн худалдааны дэглэмийг хянаж байдаг. Олон улсын худалдаатай холбоотой олон сэдвээр бичсэн судалгааны ажил, мэдээлэл ДХБ-ын эх сурвалж ([http://wto.org/english/res\\_e/res\\_e.htm](http://wto.org/english/res_e/res_e.htm)) дээр англи, франц, испани хэлээр бий.

Олон улсын бусад чухал сайтууд гэвэл:

- Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллага (<http://www.ecosecretariat.org>)
- Эдийн Засаг, Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (<http://www.oecd.org>)
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (<http://www.undp.org>)
- НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (<http://www.unctad.org>)
- Дэлхийн Худалдааны Цэгийн Холбоо (<http://www.wtpfed.org>)
- Дэлхийн Худалдааны Байгууллага (<http://www.wto.org>)

### **Судалгааны институтүүд**

Тодорхой нэг улс орон эсвэл тодорхой сэдвээр мэргэшсэн өөр бусад эх сурвалжууд бол судалгааны институтүүд, бодлогын судалгааны болон эрдэм шинжилгээний байгууллагууд байдаг. АНУ-д байдаг Эдийн засгийн Судалгааны Үндэсний Товчоо (<http://www.nber.org>) бол ийм судалгааны институт юм. Түүний сайтад энэ чиглэлээр, ялангуяа шинээр төрөн гарсан зах зээлүүдийн эдийн засгийн хямралын тухай бичигдсэн сэтгүүлийн өгүүлэл, ажлын тайлан, эдийн засгийн суурь судалгаа орсон байдаг. (Бодлогын судалгааны болон эрдэм шинжилгээний судалгааны институтүүдийн жагсаалтыг <http://www.worldpress.org/library/ngo.htm> хаягаар авч болно)

Дэлхийн өнцөг булан бүрт буй бизнесийн болон олон улсын харилцааны тэргүүлэх сургуулиудын болон мэргэжилтнүүдийн талаар мэдээлэл олъё гэвэл Харвардын Их Сургууль (<http://www.harvard.edu>), Стэнфордын Их Сургууль (<http://www.stanford.edu>), Лондоны Эдийн Засгийн Сургууль (<http://www.lse.ac.uk>), Барселон дахь IESE Бизнесийн Сургууль (<http://www.iese.edu>), Францын Фонтайнеблеай дахь INSEAD Бизнесийн сургууль (<http://www.insead.edu>) зэрэг хаягаар ороорой. Мэргэжлийн холбогдох тэнхимийн вэб сайтууд бас маш сайн эх сурвалж болдог. Ийм нэг сайтыг Нью Йоркийн Их Сургуулийн бизнесийн профессор Ноуриел Роубини эрхлэн ажиллуулдаг (<http://www.stern.nyu.edu/globalmacro>).

## Компанийн тухай мэдээлэл

Хил дамнан бизнес эрхлэхийг хүсдэг ихэнх дундаж болон томоохон компаниуд вэб сайттай байдаг. Түүндээ дотоодод болон гадаадад явуулж буй үйл ажиллагааныхаа тухай иж бүрэн мэдээлэл тавьдаг. Хэрвээ ямар нэг компани вэб сайттай эсэхийг мэдэхийг хүсвэл хайлтын систем ашиглан нэрээр нь хайлт хийж үз. Түүнчлэн тухайн компанийн нэрийг вэб браузер дээрээ буулгаад төгсгөлд нь “.com” гэж бичээд туршиж үзэж болно. Хэрвээ тухайн компани нийтэд худалдаалагддаг эсвэл дэлхийн аль нэгтээ бирж дээр хувьцаагаа борлуулдаг бол уг компанийн тухай илүү өргөн дэлгэр мэдээлэл энэ компанийн хувьцаагаа худалдаалдаг биржийн зохицуулах

Хил дамнан бизнес эрхлэхийг хүсдэг ихэнх дундаж болон томоохон компаниуд нь өөрсдийн вэб сайттай байдаг. Түүндээ дотоодод болон гадаадад явуулж байгаа үйл ажиллагааныхаа тухай иж бүрэн мэдээллийг тавьсан байдаг.

газар дээр байх ёстой. АНУ-д ийм зохицуулах газрыг нь Үнэт цаас ба биржийн хороо (SEC) гэх бөгөөд вэб сайттай нь <http://www.sec.gov> хаягаар танилцаж болно. АНУ-ын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа худалдахыг хүссэн гадаад, дотоодын аль ч компани мэдээлэл, бичиг баримтуудаа уг комисст тогтмол илгээж байх ёстой.

Хэрэв таны сонирхон судалж байгаа компани АНУ-ын бирж дээр хувьцаа худалддаггүй бол тус компанийн талаар ҮЦБХ буюу SEC-н вэб сайтаас мэдээлэл олж авч чадахгүй билээ. Энэ тохиолдолд тухайн компанийн хувьцаа худалдаалагддаг орны зохицуулах газарт хандах хэрэгтэй болно. Нью

Йоркийн хөрөнгийн бирж (<http://www.nyse.com>) тус бирж дээр худалдаа хийдэг АНУ-ын бус компаниудын жагсаалтыг төдийгүй дэлхийн өнцөг булан бүрт буй хөрөнгийн биржүүдтэй холбох илүү бүрэн дүүрэн жагсаалт гаргаж байдаг.

Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартуудын тухай танилцуулга, дэлхийн хэмжээний бүртгэлийн стандартуудыг дэлгэрүүлэх хүчин чармайлтуудын тухай нягтлан бодох бүртгэлийн Deloitte Touche Tohmatsu компани <http://www.iasplus.com/resource/ref.htm> хаягаараа маш сайн вэб хуудас ажиллуулдаг.

## Экспорт, худалдаа, бараа түүхий эд

Хэд хэдэн орны засгийн газар, түүний дотор АНУ, Европын Холбооны орнуудын засгийн газар худалдаа, экспорт, бараа түүхий эдийн тухай их

хэмжээний мэдээллээр хангаж байдаг. Эдгээр мэдээлэл нь мөн л түүнийг түгээн гаргаж байгаа засгийн газрын ашиг сонирхлыг ямагт илэрхийлдэг учир баттай болоход нь хэт найдаж болохгүй.

АНУ-ын Засгийн газрын экспортын портал (<http://www.export.gov>) дээр улс орнууд ба үйлдвэрлэлийн зах зээлийн судалгааг танилцуулж, Мексик, АНУ, Канад улсуудыг нэгтгэсэн Хойд Америкийн Чөлөөт Худалдааны Гэрээ (NAFTA) болон тарифийн тухай вэб сайтуудтай холбож өгсөн байдаг. АНУ-ын Хөдөө аж ахуйн Департаментийн Гадаад Хөдөө аж ахуйн Алба (<http://www.fas.usda.gov>) бас тухайн салбарын мэдээ тайлан, худалдааны бодлого, яриа хэлэлцээрүүд, бараа түүхий эд ба тусгайлсан улс орнууд болон өөр бусад мэдээллээр хангадаг. Энэ нь бас л АНУ-ын засгийн газрын ашиг сонирхлыг тусгасан эх сурвалж гэдгийг анхаарах хэрэгтэй.

Европын холбоо ч бас гадаад худалдааны вэб хуудастай ([http://europa.eu.int/pol/comm/index\\_en.htm](http://europa.eu.int/pol/comm/index_en.htm)) бөгөөд эндээс та экспорт, импортын дэглэм, түүнчлэн ДХБ-аар шийдэгдэх гэж байгаа янз бүрийн хэргүүдийн талаар мэдээлэл олж авч болно.

Бараа түүхий эдийн тухай мэдээллийн хувьд аж үйлдвэрийн холбоод, бараа түүхий эдийн судалгааны компаниудыг хайх хэрэгтэй. Спаркс (Sparks)-н (<http://www.sparksc.com>) сайтад бараа түүхий эдийн бирж дээрх хамгийн гол зарим тоглогч, элементүүдийн тухай өргөн хүрээтэй жагсаалт гаргаж байршуулсан байдаг. Бараа түүхий эдийн үнэ ханш, борлуулалтын хувьд эдгээрийг арилжаалж буй биржүүдийн сайтад орж үзэх нь чухал. Чикагогийн Худалдааны Зөвлөл (<http://www.cbote.com>) бол АНУ дахь бараа түүхий эдийн арилжааны нэг гол зах юм. Энд эрдэнэшиш, шар буурцаг, мал, амьтны гаралтай хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн борлуулах хандлагатай байдаг бол Нью Йоркийн Худалдааны Зөвлөлд (<http://www.nybota.com>) кофе, элсэн чихэр, какао, бөс даавуу, жүржийн шүүс гэх мэт бүтээгдэхүүн худалдаалагддаг.

## **Идэвхтэй бүлгүүд**

Хорвоогийн бараг бүх сэдвээр сонирхогч, идэвхтнүүдийн вэб сайт байдаг. Дор та бүхэн Дэлхийн Банкинд хөндлөнгийн хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг бүлгүүд болон хямд хөлсөөр ажиллуулдаг газруудын (хүмүүсийг маш бага хөлсөөр нөхцөл муу орчинд ажиллуулдаг үйлдвэрүүд) сэдвээр тэмцдэг бүлгүүдийн вэб сайтуудын жишээг авч үзэх болно. Идэвхтнүүд ч бас засгийн газар, компаниудын нэг адил ямар нэг байдлаар нэг талыг барьсан хандлага гаргадаг, иймд өөр бусад үзэл бодолтой харьцуулан тэнцвэржүүлж ойлгох хэрэгтэй гэдгийг санаарай.

## **Дэлхийн Банкны хөндлөнгийн хяналтын бүлгүүд:**

- “50 жил хангалттай: Дэлхий нийтийн эдийн засгийн шударга ёсны төлөөх АНУ-ын сүлжээ” (50 Years Is Enough: U.S. Network for Global

Economic Justice) (<http://www.50years.org/about/>) хэмээх бүлэг бол “эдийн засгийн суурь боловсролын сургалт, олон нийтийн хөдөлгөөн, бодлогын нөлөөлөл”-өөрөө дамжуулан Дэлхийн Банк, ОУВС дахь ил тод, хариуцлагатай байдлыг хөхиүлэн дэмжих чиглэлээр хамтран ажилладаг ТББ-ууд болон идэвхтэн бүлгүүдийн сүлжээ юм.

- Банкны Мэдээллийн Төв (Bank Information Center) (<http://www.bicusa.org>) нь үүнтэй төстэй зорилгоор өөрсдийн үйлчилж байгаа хөгжиж байгаа орнуудын ард түмний өмнө олон улсын санхүүгийн байгууллагууд нь хариуцлага хүлээдэг болгохыг хичээдэг. Зорилгоо хэрэгжүүлэхдээ тэд “иргэний оролцоо, мэдээллийн ил тод байдал, байгаль орчны болон нийгмийн бодлогуудыг бүрэн дагаж мөрдөх, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх” зэрэг зарчмуудыг баримталдаг.

### **Хямд хөлсөөр ажиллуулдаг газруудын эсрэг ажиглагч бүлгүүд:**

- Энд нэгд! (Unite Here!)(<http://unitehere.org>) бүлэг нь хямд хөлсөөр ажиллуулдаг газрууд болон нийгмийн бусад асуудалд цэг тавих талаар бүхий л эх сурвалжуудтай сайн холбож өгдөг.
- Хямд хөлсөөр ажиллуулдаг хөдөлмөрийн эсрэг эрдэмтэн судлаачид (Scholars Against Sweatshop Labor) (<http://www.umass.edu/peri/sasl/>) өөрийн вэб сайт ажиллуулдаг бөгөөд хямд хөлсөөр ажиллуулдаг газруудын маргаантай асуудлаарх нийтлэлүүд, энэ мэтгэлцээнд оролцож буй янз бүрийн бүлгүүдтэй холбож өгдөг.
- Өөр бүлэг нь чөлөөт худалдааны чиглэлийн эрдэмтэн судлаачид үзэл бодлоо илэрхийлдэг Олон Улсын Худалдааны Академийн Консорциум (Academic Consortium on International Trade)-ын <http://www.fordschool.umich.edu/rsie/acit/> вэб сайтад хандаж болно. Мөн үүний эсрэг өөр үзэл бодолтой танилцах боломж ч энд бий.



# Хавсралт А

Бүс нутгийн улс төр, нийгэм, эдийн засгийн онлайн эх сурвалжуудад нэвтрэх үүд хаалга болсон сайтуудаас цөөн хэдийг дор үзүүлэв.

## Латин Америк

**Латин Америкийн Сүлжээний Мэдээллийн Төв** (Latin American Network Information Center) (<http://lanic.utexas.edu>) бол Аустин дахь Техасийн Их сургуулиас эрхлэн ажиллуулдаг маш сайн эх сурвалж бөгөөд эдийн засаг, сэтгүүл зүй, байгаль орчин гэх мэт тодорхой сэдвээр, улс орон бүрийн эх сурвалжуудад хандах боломжийг олгодог.

## Орос ба Зүүн Европ

**Орос ба Зүүн Европ Судлалын Виртуал Номын Сан** (Russian and East European Studies Virtual Library) (<http://www.ucis.pitt.edu/reesweb/index.shtml>) -г Питтсбургийн Их сургуулийн дэргэдэх Орос ба Зүүн Европ Судлалын Төвөөс хариуцан ажиллуулдаг, электрон эх сурвалжуудаас судлах зүйл, бүс нутаг, цаг хугацааны хайлт хийх боломжийг сэтгүүлчдэд олгодог.

## Африк

**Африкийн Эдийн засгийн Сэтгүүлчдийн Чуулга уулзалт** (African Economics Journalists Forum) (<http://www.afriforum.org/countryinfo.htm>) сайт нь Африк дахь улс төр, эдийн засаг, эрх зүйн нөхцөл байдлын талаарх өргөн хүрээтэй мэдээллүүдийг байршуулсан байдаг.

**Африкийн эдийн засгийн бусад байгууллага:**

**Африкийн Холбоо** (African Union)(<http://www.au2002.gov.za>)

**Зүүн Африкийн Хамтын Нийгэмлэг** (East African Community)(<http://www.eacq.org>)

**Африкийн Хөгжлийн төлөө Шинэ Түншлэл** (New Partnership for Africa's Development)(<http://www.nepad.org>)

**Өмнөд Африкийн Хөгжлийн Хамтын Нийгэмлэг** (Southern African Development Community)(<http://www.sadc.int>)

## **Ази**

Ази Номхон далай буюу **Asia Pacific.com** (<http://www.asia-pacific.com/links.htm>) нь энэ бүсийн бизнес, эдийн засгийн эх сурвалжуудад өргөнөөр нэвтрэх үүд хаалга болдог.

### **Азийн эдийн засгийн бусад байгууллага:**

**Азийн Хөгжлийн Банк** (Asian Development Bank)(<http://www.adb.org>)

**Ази-Европын Сан** (Asia-Europe Foundation)(<http://www.asef.org>)

**Ази, Номхон Далайн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа** (Asia Pacific Economic Cooperation)(<http://www.apecsec.org.sg>)

**Номхон Далайн Арлуудын Чуулга Уулзалтын Нарийн Бичгийн Газар** (Pacific Islands Forum Secretariat)(<http://www.forumsec.org.fj>)

**Бүс Нутгийн Хамтын Ажиллагааны төлөө Зүүн Азийн Холбоо** (South Asian Association for Regional Cooperation)(<http://www.saar-sec.org>)

### **Ойрхи дорнод:**

**Арабнэт буюу ArabNet** (<http://www.arab.net>) нь тус бүс нутгийн мэдээ, улс орны ерөнхий мэдээлэл, Арабын ертөнцийн онлайн эх сурвалжуудтай танилцах сувгуудыг тавьсан байдаг.



## Нэр томъёоны тайлбар

**Ажил эрхлэлт:** Цалин хөлс олгож байгаа ямар нэг ажил.

**Ажил эрхлэлтийн тоо:** Хууль эрхийн хүрээнд ажил эрхэлж буй ажилчдын, түүний дотор хувиараа хөдөлмөр эрхлэгчид, гэр бүлийн цалингүй ажилчид, гэрийн ажил хийдэг хүмүүс, ажил хаялт хийсэн ажилчдыг нийтэд нь тооцсон тоо. Ажил эрхлэлтийн тоог аливаа улс үндэстний эдийн засгийн тогтвортой байдлын нэг үзүүлэлт болгон авч үзэх нь олонтаа байдаг.

**Ажилгүйдлийн хувь:** Ажилгүй гэсэн ангилалд хамрагдаж буй хүмүүсийн тоог нийт ажиллах хүчний тоонд харьцуулсан харьцаа.

**Ажилгүйчүүд:** Сайн дурын бус үндсэн дээр ажилгүй байгаа хүмүүс.

**Ажиллах хүч:** Ямар нэг улс орон буюу бүс нутагт ажил эрхэлж байгаа эсвэл хайж байгаа хүмүүсийн нийт тоо.

**Азийн Хөгжлийн Банк:** Ази, Номхон далайн орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийг зээл, техникийн туслалцаа үзүүлэх замаар дэмжих зорилгоор 1966 онд байгуулагдсан бүс нутгийн хөгжлийн банк. Одоогоор 59 гишүүн оронтой.

**Албан ёсны зээлдүүлэгч бүлэглэлүүд (Парисийн клуб гэх мэт):** Францын Ерөнхий сайдын удирдлага дор Парист тогтмол уулздаг засгийн газрын зээлдүүлэгч нар. Тухайн өртэй улс орны засгийн газар болон түүнд оролцогч бүх засгийн газруудын хооронд олон талт гэрээ хэлэлцээр байгуулсны дүнд хоёр талын албан ёсны өрийг төлөх хугацааг хойшлуулж, өөрчлөх саналуудыг тэд хэлэлцэн тохиролцдог.

**Алдагдал:** Өр төлбөр нь хөрөнгөөсөө, алдагдал нь ашгаасаа, эсвэл орлогоосоо зарлага нь давах явдал.

**Алдагдсан боломжийн өртөг:** Ямар нэг тодорхой үйл ажиллагааг дагнан явуулснаар алдагдах хамгийн сайн боломжит хувилбар.

**Америк хоорондын Хөгжлийн Банк:** Улсын байгууллагуудад зээл олгох, хувийн дэд бүтэц болон хөрөнгийн зах зээл хөгжүүлэх төслүүдийг санхүүжүүлэх замаар Латин Америк, Карибийн бүс нутаг дахь эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх зорилгоор байгуулагдсан Вашингтон хотод төвтэй байгууллага.

**Арилжаалагчид:** Өөрсөддөө эсвэл үйлчлүүлэгчийнхээ нэрийн өмнөөс ашиг олох зорилгоор үнэт цаас болон түүнтэй холбогдох зүйлсийг худалдаалж буй хүмүүс.

**Арилжааны бичиг:** Корпорациудаас гаргадаг богино хугацааны баталгаажуулаагүй амлалтын бичиг. Арилжааны бичгийн хүчинтэй хугацаа ихэвчлэн 270 хоногоос доош байдаг, хамгийн нийтлэг хүчинтэй хугацаа нь 30-50 хоног, түүнээс доош хугацаатай байдаг.

**Арилжааны хэмжээ:** Ямар нэг үнэт цаас эсвэл нийт арилжааны тодорхой хугацаанд арилжигдсан хувьцаа, бонд буюу гэрээний тоо.

**Ашиг орлого:** Ямар нэг компанийн өгөгдсөн хугацаанд олсон цэвэр орлого; хөгжилтэй орны компаниуд ашиг орлогоо улирал тутам тайлагнадаг.

**Ашиг хүртэх:** Хувьцаагаа худалдахыг хүсч байгаа хөрөнгө оруулагчдын саналаар хөрөнгийн эсвэл нийт зах зээл дээр борлуулалт явагдаж, улмаар тухайн хувьцааны үнийг хэтэрхий өндөр үнэлж ойлгосноос болж эсвэл таагүй мэдээ, таамаглалаас үүдэн ашиг олохыг ойлгуулахад ашигладаг хэллэг.

**Ашигт ажиллагаа:** Аливаа компанийн үйлдвэрлэлийн явцад гарсан өртөг зардлаасаа илүү орлого бий болгох чадвар

**Бага орлоготой үйл ажиллагаа:** Үр өгөөж багатай эсвэл ашгийн түвшин доогуур бараа, үйлчилгээнүүд

**Банкны систем:** Аливаа орны бүх арилжааны банкуудын нийлбэр цогцыг хэлнэ. Эдгээр банкууд нь хүмүүсийн хадгаламжийг хүлээн авч, эргүүлээд зээлдүүлдэг, түүнийхээ багахан хувийг хадгаламж эзэмшигчдийн мөнгөө эргүүлж авах хэрэгцээнд зориулан нөөцөндөө үлдээдэг.

**Бараа түүхий эд:** Бараа түүхий эд бол хөрөнгө оруулагчид ихэвчлэн фючерс буюу ирээдүйд худалдан авах гэрээгээр дамжуулан худалдаж, худалдан авч байдаг хүнсний бараа, метал, өөр бусад биет бүтээгдэхүүн байдаг.

**Бараа түүхий эдийн үнэ:** Хөрөнгө оруулагчид ихэвчлэн фючерс буюу ирээдүйд худалдан авах гэрээгээр дамжуулан худалдаж, худалдан авч байдаг хүнсний зүйл, метал, өөр бусад биет зүйлийн үнэ.

**Бараа түүхий эдийн маркетингийн зөвлөлүүд:** Маркетингийн арга хэрэгслүүд, квот, лиценз, үйлдвэрлэгчийн татвар хураамж, үнэ тогтоолт зэргийг хянах замаар бараа түүхий эдийн маркетингид хяналт тавих үүрэгтэй, ихэвчлэн засгийн газрын хяналтан дор үйлдвэрлэгчээс ажиллуулдаг байгууллага.

**Барааны сагс:** Жирийн нэг өрхийн хэрэглэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний сонголт. Хэрэглэгчийн үнийн индекс болон үйлдвэрлэгчийн үнийн индексийг тооцоолоход хэрэглэдэг.

**Бүтцийн өөрчлөлт:** Эдийн засгийн ажил эрхлэлт, баялаг бий болгох арга замд оруулах байнгын суурь өөрчлөлт. Үүнд харьцангуй ач холбогдолтой эдийн засгийн салбаруудад, бүс нутгийн эдийн засгийн хүчин чадалд, эсвэл

ажиллах хүчний ур чадвар, мэргэжлийн бүтцэд хийх өөрчлөлтүүд орно.

**Болзолт нөхцөл:** Зээл болон буцалтгүй тусламж олгохдоо нөхцөл заах бодлоготой холбоотой нэр томъёо. Эдгээр нөхцөл болзол нь хүлээн авагч улс орон мөнгөнийхөө ханшийг бууруулах, үнийн хяналтыг зогсоох, төсвөө танах, худалдаа болон хөрөнгийн урсгалд учирч буй саад бэрхшээлүүдийг багасгахыг шаардаж болох бөгөөд Олон улсын валютын сан, Дэлхийн банк болон олон улсын санхүүгийн бусад байгууллагууд олонтаа хэрэглэдэг. Ийм нөхцөл болзлууд улс төрийн хувьд тааламжтай бус байж дор хаяж л эдийн засгийн богино хугацааны хүндрэлд хүргэж мэдэх бөгөөд хүлээн авагч улс орны тусгаар, дотоод байдалд хөндлөнгөөс оролцсон гэдэг талаасаа шүүмжлэгчдийн бай болж байдаг.

**Бонд:** Нэгээс дээш жилийн хугацаагаар гаргасан өрийн бичгийг бонд гэнэ . АНУ-ын засгийн газар, орон нутгийн засгийн газрууд, ус хангамжийн дүүргүүд, компаниуд болон бусад олон төрлийн байгууллага бонд худалддаг. Аливаа хөрөнгө оруулагч бонд худалдаж авснаар мөнгө зээлдүүлж байна гэсэн үг. Бонд худалдагч тодорхой хугацааны дараа зээлийн үндсэн төлбөрийг буцаан төлөхөөр тохирч байна гэсэн үг. Хүүтэй бондууд тодорхой цаг хугацаанд хүү төлдөг.

**Бондын хүү:** Энэ нь зээлдэгчээс худалдан авагчид тодорхой хэмжээний төлбөр эргүүлэн төлөхөөр амлан гаргаж байгаа бондын үнэ бөгөөд ихэвчлэн хүүгийн төлбөр дээр тохирсон хугацааны эцэст эргүүлэн төлөх үндсэн төлбөрийг нэмж тооцдог.

**Бэйлаут буюу батлан даалт:** Ихэвчлэн санхүүгийн хүндрэлд орсон компани эсвэл агентлагийг аврахын тулд засгийн газрын эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлдэг аврах ажиллагаа. Мөн засгийн газруудыг өөрсдийг нь аварч болох бөгөөд үүнийг Олон Улсын Валютын Сан (ОУВС) ба бусад зээлдүүлэгчид зээл олгох замаар хэрэгжүүлдэг.

**Валют:** Мөнгө.

**Валютын зах зээл:** Зах зээлийн үнийг тогтоохын тулд эрэлт, нийлүүлэлт хоёрын хооронд болон тухайн улсын мөнгийг худалдан авч, худалдаж буй хэмжээний хооронд явагдаж буй харилцан үйлчлэл.

**Валютын үнэгүйдэл:** Валютын тогтмол ханш хадгалагдах үед аль нэг валютын ханш сулрахыг хэлнэ.

**Валютын ханш:** Нэг улс орны валютыг нөгөө улсын валютаар илэрхийлсэн үнэ.

**Гадаад валют:** Өөр улсын валют.

**Гадаад үзүүлэлтүүд:** Тухайн улсын засгийн газар болон дотоодын үйлдвэрлэлээс гадуурхи хүчин зүйлс.

**Гадаад хүчин зүйлс:** Аливаа эдийн засгийн ажил үйлчилгээг эрхлэхэд шууд оролцогч этгээдүүдээс үл хамааран гарч болох ашиг хонжоо, өртөг зардал.

**Гадаадын хөрөнгө оруулалт:** Нэг улс орны хувь хүн, пүүс компанийн хөрөнгийг өөр улс орны хувь хүн, пүүс компани худалдан авах. Үүнд шууд болон үнэт цаасны портфелийн хөрөнгө оруулалт аль аль нь орно.

**Гадаадын шууд хөрөнгө оруулалт:** Хилийн чанадад үйлдвэр, тоног төхөөрөмж гэх мэт биет хөрөнгийг эх корпорацийн үйл ажиллагааны хяналттайгаар худалдан авах ажиллагаа.

**Голланд өвчин:** Аливаа улс үндэстэн байгалийн ямар нэг нөөц баялаг нээж олох үед тухайн улсын үндэсний валютын ханш өсч, улмаар үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн нь бусад улсуудтай өрсөлдөх чадвар муутай болж, импортыг нэмэгдүүлэн, экспортыг бууруулах нөлөө үзүүлэх үед тухайн улсын үйлдвэржилт саарах үзэгдэл. Энэ нэр томъёо нь 1960-аад оны үед Хойд Тэнгисээс байгалийн хийн орд газар олж нээсэн Голланд улсаас гаралтай.

**Дампуурал:** Өмч хөрөнгөөсөө хэтэрсэн өр төлбөртэй эсвэл хөрөнгийн үнэт чанар нь алдагдсан үед хууль ёсоор шүүхэд шүүгдэж байгаа ямар нэг пүүс компанийн санхүүгийн байдал.

**Дефолт буюу эргэн төлөх чадвараа алдах:** Ямар нэг өрийн бичгийн үндсэн буюу хүүгийн төлбөрийг хуагцаанд нь төлж чадахгүй байх эсвэл бондын гэрээний заалтуудыг ёсчлон биелүүлж чадахгүй байх явдал.

**Динамик харьцангуй давуу тал:** Зах зээлийн өөрчлөлтийн хариуд нэг улс нөгөөгөөсөө арай бага алдагдсан боломжийн өртгөөр өгөгдсөн хэмжээний бараа, үйлчилгээг үйлдвэрлэн гаргах чадвар.

**Дистрибьютор:** Бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс нь авч ямар нэг үнэ нэмэн жижиглэн худалдааныханд борлуулж байгаа бөөний худалдааны дундын зуучлагч.

**Дотогш урсгал:** Аливаа эдийн засагт гадаадад үзүүлсэн үйлчилгээнээс орж ирж байгаа хөрөнгийн хэмжээ.

**Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ):** Аливаа оронд өгөгдсөн хугацаанд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнэ, түүний дотор тухайлбал АНУ-д үйл ажиллагаагаа явуулж буй гадаадын корпорациуд, гадаадын оршин суугч иргэдийн олсон орлого багтах боловч хилийн чанадад байгаа АНУ-ын иргэд, корпорациудын орлого орохгүй.

**Дэд бүтцийн байгууламж:** Аливаа улс орон эсвэл газар нутаг нэгэн эдийн засаг, нэгэн төр улс болж оршихын тулд тэнд байвал зохих хэрэгслүүдийн дэд бүтэц, түүний дотор тээвэр, харилцаа холбоо, усан ба эрчим хүчний хангамжид шаардлагатай хөрөнгө, аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний байгууллагууд орно.

**Дэд бүтэц:** Тээвэр, харилцаа холбооны систем, усан ба эрчим хүчний хангамж, төрийн байгууллагууд гэх мэт аливаа нийгмийн үйл ажиллагаанд зориулагдсан үндсэн хэрэгсэл, суурь үйлчилгээнүүд.

**Дэлхийн Банк:** Хөгжиж байгаа орнуудад санхүүгийн дэмжлэг, техникийн туслалцаа үзүүлдэг, дэлхийн өнцөг булан бүрт хэрэгжиж буй төсөл, санаачлагуудын талаарх мэдээллээр хангахаар байгуулагдсан.

**Дэлхийн Худалдааны Байгууллага:** Дэлхий нийтийн худалдааны дүрэм, журмуудыг сахиулж, хяналт тавьж байдаг Швейцарийн Женевт төвтэй олон улсын байгууллага.

**Өөрийн хөрөнгө:** Эзэмшигчийн хөрөнгө, түүний өр төлбөрөөс давсан үнийн дүн. Ямар нэг корпорацийн хувьцаа эзэмшигчийн өөрийн хөрөнгө нь түүний эзэмшиж буй хувьцааны үнийн дүн байдаг. Орон сууц эзэмшигчийн өөрийн хөрөнгө нь тухайн байшингийн үнэ ба орон сууцны зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл хоёрын зөрүү байна.

**Жижиглэн худалдаа:** Барааг бага хэмжээгээр хэрэглэгчид шууд худалдах.

**Жилийн тайлан:** Нийтийн өмчийн ямар нэг компанийн санхүүгийн байдлын жилийн тайлан. Үүнд тухайн компанийн үйл ажиллагааны танилцуулга, тайлан тэнцэл, орлогын тайлан багтдаг. АНУ-ын Үнэт цаас болон арилжааны комиссоос бүх хувьцаа эзэмшигчиддээ тайлангаа гаргаж танилцуулахыг шаарддаг.

**Зай (Spread):** (1) Ямар нэг хувьцаа болон бусад үнэт цаасны дуудагдаж байгаа, асууж байгаа үнийн зөрүү. (2) Ямар нэг пүүс компаниас гаргасан бүтээгдэхүүнийг хариуцагч тал хүлээн авч байгаа үнэ, түүнийгээ нийтэд худалдаж байгаа үнэ хоёрын зөрүү. (3) Зээлдэгч мөнгө зээлэхдээ тогтоосон тогтмол орлогын жишиг хэмжээнээс дээгүүр төлж буй үнэ.

**Засгийн газрын оролцоо:** Засгийн газраас эдийн засагт оролцож байгаа ямар нэг оролцоо. Үүнд засгийн газраас ажил эрхлэлт, үнийг тогтворжуулахын тулд татварын хувийг өөрчлөн тохируулах асуудал орно. Энэ нь чухамдаа чөлөөт зах зээлийн эсрэг чиглэгддэг.

**Зах зээлд эзлэх хувь:** Тодорхой нэг компанийн хяналтад байгаа борлуулалтын тухайн салбарын нийт борлуулалтад эзлэх хувь.

**Зах зээлийн үнэ:** Худалдагч ба худалдан авагч этгээдүүд бие биенээс хамааралгүй, зөвхөн арилжааны ашиг сонирхлын үүднээс солилцоо хийж байгаа тохиолдолд ямар нэг зүйлийг худалдан авахад бэлэн байгаа этгээдээс түүнийг худалдахад бэлэн байгаа этгээдэд төлж байгаа мөнгөний хэмжээг хэлнэ.

**Зогсонги байдал:** Эдийн засгийн уналт бууралтын үе. Нэн ялангуяа ДНБ хоёр буюу түүнээс дээш жилийн турш дараалан буурахад хэрэглэгддэг ойлголт.

**Зэрэглэл:** Харьцуулах зорилгоор урьдчилан тодорхойлсон үнэт цаасны жагсаалтыг гаргах үйл ажиллагаа. Ийм жагсаалт нь өмнө нийтлэгдсэн индексүүдэд тулгуурлан эсвэл ямар нэг хөрөнгө оруулалтын стратегид тохируулан сонгосон байж болно.

**Импорт:** Нэг улс орон нөгөөгөөс худалдан авч байгаа бараа, үйлчилгээ. Экспортын эсрэг утгатай.

**Инфляци:** Бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өсч байгаа хувь хэмжээ.

**Капитал:** Аливаа компанийн цэвэр хөрөнгө, түүний дотор олсон орлогууд орно.

**Компани худалдан авалт:** Худалдан авагч компани, санхүүгийн хөрөнгийг нь худалдан авч байгаа компаниудын нэгдэлт буюу нийлэлт.

**Контагионы нөлөө:** Өмчлөгчийн хөрөнгө буюу бондын үр өгөөжийн хэт хамаарал. Эдийн засагчид үүнийг аливаа эдийн засгийн хүндрэл бэрхшээл нэг улсаас нөгөөд дамжин газар авах явдлыг илэрхийлэхдээ хэрэглэдэг. 1997 оны Азийн хямралын үед хүндрэлтэй байдал Тайландаас эхэлж улмаар тухайн бүс нутгийг тэр чигт нь хамарсан учраас энэ хямрал нь контагионы тод жишээ юм.

**Лондоны клуб:** Тусгаар тогтносон бүрэн эрхт улсуудын төр засагт хамаарах өрийг худалдан авч барьж байдаг хувийн зээлдүүлэгч нар үүнд хамаарна.

**Макро эдийн засаг:** Аливаа улсын эдийн засгийг бүхэлд нь авч үзэж, судалдаг шинжилгээ.

**Мөнгөн хэрэгслүүд:** Холбооны үнэт цаас, хадгаламжийн гэрчилгээ, арилжааны бичиг гэх мэт томоохон хэмжээний мөнгө.

**Мөнгөний бааз суурь:** Валютын нөөц, төв банкны нөөц нийлээд хэсэгчилсэн нөөцтэй банкны үйл ажиллагаатай үеийн мөнгөний нийлүүлэлтийн бааз суурь болж байдаг.

**Мөнгөний бодлого:** Мөнгөний нийлүүлэлт, хүүгийн хувийг хянах замаар засгийн газраас эдийн засагт үзүүлэх нөлөө.

**Мөнгөний үнэ:** Хүүгийн хувь.

**Микро эдийн засаг:** Компани, салбар, айл өрх гэх мэт эдийн засгийн бие даасан нэгжүүдийн үйл хөдлөлийг судалдаг шинжилгээ.

**Монополь:** Ямар нэг бүтээгдэхүүн, үйлчилгээ ганцхан борлуулагчтай байх нөхцөл байдал.

**Нийгмийн шилжилт хөдөлгөөн:** Улс төрийн өөрчлөлт, эдийн засгийн хүндрэл, нүүдэл, ургац алдах болон нэг бүс нутгаас нөгөөд шилжих хөдөлгөөнийг өдөөгч бусад хүчин зүйлсээс болж гарсан шилжилт хөдөлгөөн.

**Нийлүүлэгчид:** Өөр компанид эд анги нийлүүлдэг эсвэл үйлчилгээ үзүүлдэг ямар нэг компани.

**Нийлүүлэлт:** Худалдан авахад бэлэн байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт дүн, эрэлтийн хамт үнийн хоёр гол тодорхойлогчийн нэг болдог.

**Нийтэд худалдаалагдах компани:** Дэлхийн хаа нэгтээ бирж дээр хувьцаа худалддаг компани.

**Ногоон:** АНУ-ын долларыг илэрхийлдэг ярианы хэллэг.

**Нэг хүнд ногдох:** Нэг хүнд ногдох нэгжийг харуулдаг хэмжүүр, нийт дүн болон нэгтгэсэн тоон илэрхийллийн эсрэг утгатай.

**Нэгдэгчид:** (1) Худалдан авагч тал бүх хөрөнгө, өр төлбөрийг нь шилжүүлэн авч байгаа худалдан авалт (2) Ерөнхий утгаараа, хоёр компани ямар нэг байдлаар нэгдэхийг хэлнэ.

**Олон талт институт:** Дор хаяж гурван улс орон оролцсон ямар нэг байгууллага.

**Олон улсын буюу гадаад валютын цэвэр нөөц:** Аливаа улс орны төв банкинд ихэвчлэн доллараар байдаг нөөц сан. Энэ нөөцийн хэмжээг аливаа улс орон импортоо болон гадаад валютын өрөө төлөх чадварыг хэмжих нэг хэмжүүр болгон ашиглах нь олонтаа.

**Олон Улсын Валютын Сан:** Валютын ханшаа тогтворжуулах эсвэл төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй байдлаа багасгах шаардлагатай байгаа орнуудад богино хугацааны санхүүгийн туслалцаа үзүүлэх зорилгоор 1944 онд байгуулагдсан олон улсын байгууллага. 1980-аад оноос хойш ОУВС нь улс үндэстнүүдэд тодорхой болзлоор олгож байгаа зээлээрээ дамжуулан тэдгээр орнуудын эдийн засгийн шийдвэр гаргалтад улам бүр оролцдог болоод байна.

**Олон Улсын Зохицуулалтын Банк:** Швейцарийн Базелд төвтэй энэхүү олон улсын банк нь Европын хэд хэдэн төв банкууд, Японы Төв Банк, АНУ-ын Холбооны Нөөцийн Системийн хооронд мөнгөний талаар хамтын ажиллагаа явуулахад зориулсан яриа хэлэлцээрийн талбар болдог. 1930 онд дэлхийн I дайны үеийн Германы нөхөн төлбөрийг шийдвэрлэхээр байгуулагдсан, одоо олон улсын банкны үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, хяналт шинжилгээ хийдэг, олон улсын банкны зохицуулалттай холбоотой дүрэм, журмуудыг түгээн дэлгэрүүлдэг.

**Орлого:** Ямар нэг хасалт хийхээс өмнөх нийт орлогын дүн.

**Өмч хувьчлал:** Төрийн өмчийн болон төрөөс удирдан явуулдаг компаниудыг ихэвчлэн худалдах замаар хувийн салбарт шилжүүлэх үйл ажиллагаа.

**Өр барагдуулалт:** Аливаа өрийн хүүгийн төлбөрийг төлөх зардал.

**Өр:** Зээлсэн мөнгө.

**Өргөжилт:** Эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагаа ихэссэн үе.

Өсөлтийн шатандаа явж байгаа тодорхой нэг бизнес буюу салбарт хамаарна.

**Өргөн хэрэглээний бараа:** Хэрэглэгчийн хувийн хэрэгцээндээ худалдан авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээ.

**Өрийн хэлэлцээр:** Зээлдэгч зээлийн төлбөрөө төлж чадахгүйд хүрэх эсвэл эргэн төлөх чадвараа алдахаас эмээж өрийнхөө хэмжээг бууруулж өгөхийг хүсч байгаа үед явагддаг зээлдэгч ба зээлдүүлэгчийн хоорондын яриа хэлэлцээр.

**Өсөлтийн хувь:** Ихэвчлэн хүүгийн хувийн өсөлттэй холбож хэрэглэдэг.

**Ралли:** Үнэ өсөх хандлага. Реакцийн эсрэг утгатай.

**Реакци:** Хэсэг хугацаанд үнэ өссөний дараа буурах үзэгдэл. Раллигийн эсрэг утгатай.

**Сингапурын бараа түүхий эдийн бирж:** Сингапурт төвтэй, бараа түүхий эдийн фючерсүүдийг арилжаалахад зориулсан төвлөрсөн, зохицуулалттай зах зээлийн газар.

**Тансаг хэрэглээний бараа:** Чинээлэг хэрэглэгч нарт өндөр үнээр зардаг ховор чамин бараа. Эдгээрт эрдэнийн чулуун чимэг зүүлт, загвар зохион бүтээгчийн хувцас гэх мэт бараа орно.

**Татвар:** Ямар нэг үйл ажиллагаа, орлого болон бүтээгдэхүүнд засгийн газраас тогтоосон буюу ногдуулсан хураамжийг шууд татвар гэнэ. Харин бараа, болон үйлчилгээнд ногдуулсан татварыг шууд бус татвар гэнэ. Татвар ногдуулж буй гол зорилго нь засгийн газрын зарлагыг санхүүжүүлэх явдал юм.

**Татварын бодлого:** Компаниуд болон хувь хүмүүст зориулсан татвар ногдуулалтын талаарх төрийн бодлогыг илэрхийлдэг.

**Техникийн туслалцаа:** Зөвхөн мөнгөн зээл биш, бас аливаа улс орон чадавхиа дээшлүүлэхэд нь туслах зорилготой олгож буй гадаадын зээл тусламжийг илэрхийлэхэд ашигладаг. Жишээ нь, Европын нэгэн эдийн засагчийг хөгжиж байгаа орны засгийн газрын статистикийн газарт дотоодын эдийн засагчдыг сургаж хөгжүүлэхээр томилон ажиллуулж болно.

**Төв банк:** Аливаа улс үндэстний мөнгөний асуудал хариуцсан эрх бүхий гол байгууллага, төв банк нь валют гаргах, эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах зэрэг хэд хэдэн гол үүргийг гүйцэтгэдэг. АНУ-ын төв банк нь Холбооны Нөөцийн Газар юм.

**Төсвийн бодлого:** Засгийн газар өөрийн зарцуулалт ба татвар ногдуулалтаар дамжуулан эдийн засагт нөлөөлөх оролдлогууд.

**Түүхий эд:** Үйлдвэрлэлд ашигладаг байгалийн ямар нэг боловсруулаагүй материал.

**Туслах гэрээлэгч:** Ерөнхий эсвэл үндсэн гэрээлэгчийн зүгээс нийт төслийн нэг хэсэг болсон тусгай ажил үүргийг гүйцэтгүүлэхээр хөлсөлсөн хувь хүн, компани.

**Урсгал дансны тэнцэл:** Аливаа улс орны бараа, үйлчилгээний болон нэг чиглэлийн гүйлгээний (бэлэглэл) цэвэр экспортыг хэмждэг.

**Үзүүлэлтүүд:** Сонгосон чиглэлийн гүйцэтгэлийн тухай гол мэдээлэл, ихэвчлэн индекс буюу харьцаагаар илэрхийлдэг, тогтмол хугацаанд хяналт шинжилгээ хийж нэг буюу хэд хэдэн стандарттай харьцуулж үздэг.

Үзүүлэлтүүд нь ямар нэг хөтөлбөр, үйлчилгээ, эсвэл байгууллагын үйл ажиллагааны олон талыг илэрхийлэн харуулдаг.

**Үйлдвэрлэгчийн үнийн индекс:** Дотоодын бараа, үйлчилгээ үйлдвэрлэгчдийн



авч буй борлуулалтын үнийн цаг хугацааны туршид дундаж өөрчлөлтийг хэмждэг багц индекс.

**Үндсэн төлбөр:** Зээлж эсвэл зээлдүүлж байгаа мөнгөний нийт дүн.

**Үндэсний нийт бүтээгдэхүүн:** Аливаа улсын эдийн засгийн нийт орлогыг хэмждэг. Энэ нь Дотоодын нийт бүтээгдэхүүн дээр өөрийн иргэдэд гадаадаас хуримтлагдаж буй цэвэр орлогыг нэмсэнтэй тэнцэнэ.

**Үнийн санал:** Анх нийтэд санал болгосон үнэтэй ихэвчлэн холбоотой байдаг. Ямарнэг пүүс компани нийтийн өмчид шилжихдээ тухайн зах зээл дээр борлуулах хувьцааны үнийн саналаа гаргадаг.

**Үнийн хэлбэлзэл:** Арилжааны тодорхой нэг ээлжит хэсэг буюу үнийн өдрийн өөрчлөлт. Нэг ээлжит арилжаанд байж болох доод эсвэл дээд үнийг өмнөх өдрийн хаалтын ханштай харьцуулан тайлбарлахад хэрэглэх нь олонтаа байдаг.

**Үнэгүйдэл:** Ямар нэг валютын тухайн үеийн ханшийн бууралт.

**Үнэт цаас ба арилжааны хороо (SEC):** Үнэт цаасны арилжааг хянах, хөрөнгө оруулагчдыг алдаа зөрчлөөс хамгаалах үүрэгтэй АНУ-ын засгийн газрын агентлаг.

**Франчайз:** Мөхөөлдөсний дэлгүүрийн сүлжээ гэх мэт ямар нэг үйлдвэр, үйлчилгээний газар ажиллуулах эрхийн лиценз. Франчайзийн эрх авагч франчайзийн эрх олгогчийн нэр хаяг, бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах эрхтэй байдаг.

**Фючерсийн гэрээ:** Ямар нэг бараа түүхий эд, бонд, валют, хувьцааны индексийг ирээдүйн тодорхой нэг өдөр, тодорхой үнээр тухайн худалдан авагч худалдан авахад бэлэн байх болно гэж заасан гэрээ.

**Хадгаламжийн гэрчилгээ:** Мөн хугацаатай хадгаламж гэх бөгөөд энэ нь ямар нэг банк болон хуримтлалын сангаас тодорхой хэмжээний мөнгийг хадгалахаар хүлээн авсан гэдгийг гэрчлэх баримт юм. Хадгаламжийн гэрчилгээнд хадгалах хугацаа, тогтоосон хүүгийн хувийг заах бөгөөд ямар ч валютаар гаргаж болно. Хадгалах хугацаа нь хэдхэн сараас хэдэн жил хүртэл байж болно.

**Хамтарсан үйлдвэр:** Хоёр буюу хэд хэдэн этгээд хамтын ашиг орлогын төлөө түншлэх эсвэл нэгдэх байдлаар хамтран ажиллаж буй ажиллагаа.

**Хариуцагч:** Хариуцагч ба төлөөлөгчийн харилцаанд төлөөлөгчийн шийдвэр нөлөөлж буй тал.

**Харьцангуй давуу тал:** Аливаа хувь хүн болон бүлгээс үйлдвэрлэл гэх мэт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд өөр нэг этгээдээс арай бага зардлаар, илүү үр ашигтай явуулах чадвар. Энэ үзэл санаа бол худалдааны онолын үндэс болдог бөгөөд эдийн засагчид яагаад улс орнууд хамгийн сайн хийж чаддаг зүйлээ үйлдвэрлэж, түүнийгээ өөрсдөө үйлдвэрлэдэггүй зүйлсээр сольж худалдаалдгийг тайлбарлахад ашигладаг.

**Хөдөө аж ахуйн салбар:** Мал аж ахуй, газар тариалан, ой мод, ан агнуур, загас агнуур зэргээс бүрдсэн эдийн засгийн нэг салбар.

**Хөдөлмөр:** Эдийн засагт хүмүүсийн оруулж буй биет болон оюуны нийт хүчин чармайлтуудыг нэгтгэсэн нөөц.

**Хөрвөх хөрөнгө:** Бэлэн мөнгөнд хялбархан, хямдаар шилжүүлж болох хөрөнгүүд, тухайлбал бэлэн мөнгө өөрөө, бас богино хугацаатай үнэт цаас орно.

**Хөрөнгө оруулалтын банкууд:** Үнэт цаасны борлуулалтад туслалцаа үзүүлэх, нэгдэх, корпорацийн өөрчлөн байгуулагдах үйл явцад туслах, үйлчлүүлэгч хувь хүн болон байгууллагуудад зуучлагчийн үүрэг гүйцэтгэх, өөрсдийн дансаар арилжаа явуулах зэрэг янз бүрийн үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн зуучлагч байгууллагууд.

**Хөрөнгө:** Ямар нэг хувь хүн, компанийн эзэмшиж буй бүх зүйл, түүний дотор мөнгө, тоног төхөөрөмж, ажилчид, барилга байгууламж, хөрөнгө оруулалт орно. Нягтлан бодох бүртгэлд компанийн нэр хүнд болон бренд нэрийг хөрөнгөнд оруулж тооцдог.

**Хөрөнгийн бирж:** Энгийн хувьцаануудыг арилжаалах арга хэрэгслүүдийг ажиглаж буй гишүүдээс бүрдсэн албан ёсны байгууллага. АНУ-ын үндэсний гол хөрөнгийн бирж бол Нью-Йоркийн хөрөнгийн бирж (NYSE), Америкийн хөрөнгийн бирж (ASE буюу AMEX) хоёр мөн. Бусад чухал биржүүдэд Амстердамын хөрөнгийн бирж, Лондоны хөрөнгийн бирж орно.

**Хөрөнгийн зах зээл:** Мөн үнэт цаасны зах зээл гэж нэрлэдэг бөгөөд үнэт цаас арилжаалахад зориулсан зах зээлийг хэлнэ.

**Хүүгийн хувь:** Мөнгө ашигласны төлөө ногдуулдаг, төлдөг төлбөр хураамж бөгөөд ихэвчлэн хувиар илэрхийлэгддэг.

**Хүчирхэг мөнгө:** Валютын нөөц дээр арилжааны банкуудад байршсан нөөцийг нэмдэг утгаараа мөнгөний бааз суурьтай адилхан.

**Хувийн ашиг сонирхол:** Төрийн бус болон олон нийтийн байгууллагуудын ашиг сонирхол. Мөн хувийн, арилжааны компаниуд байж болно.

**Хувийн зээлдүүлэгч бүлэглэлүүд:** (Лондоны клуб гэснийг үз)

**Хувьцаа гаргалт:** Аливаа компани нийтэд зориулж анх удаа хувьцаа гаргаж, санал болгох

**Хувьцаа эзэмшигч:** Ямар нэг корпораци, хамтын сангийн хэсэг хувьцааг эзэмшиж байгаа этгээд.

**Хувьцааг багцлах:** Энэ нь ямар нэг компани шинээр хувьцаа гаргах үед тохиолддог, бөгөөд харин үүнийхээ хариуд хувьцааныхаа одоогийн зах зээлийн үнийг багцлахын өмнөх хувьцааны үнэтэй харьцуулсан түвшинд бууруулахыг хэлнэ. Жишээлбэл, IBM компани буюу 2:1 харьцаагаар хөрөнгөө хуваахын өмнө хувьцаагаа 100\$-р арилжаалж байсан гэвэл багцлалт хийсний дараа хувьцаагаа 50\$-р арилжаалах бөгөөд уг хувьцааг

эзэмшигчид хуваахын өмнө эзэмшиж байснаасаа 2 дахин илүү тооны хувьцаа эзэмших болно гэсэн үг.

**Хувьцааны үнэ:** Ямар нэг корпораци, хамтын сан эсвэл хувьцааны хязгаарлагдмал түншлэлд өмчлөлийн нэг нэгжийг төлөөлүүлэн олгосон нэг гэрчилгээний үнэ.

**Хувьчлах:** Төрийн өмч, төрийн хяналтаас хувийн мэдэлд шилжүүлэх үйл явц.

**Худалдааны гэрээ:** Хоёр буюу түүнээс дээш улс орон тодорхой нөхцлүүдээр, ихэвчлэн харилцан ашигтай, хөнгөлөлттэйгээр байгуулсан гэрээ.

**Хэрэглэгч:** Бараа, үйлчилгээг ашиглаж байгаа ямар нэг хүн.

**Хэрэглээний үнийн индекс (ХҮИ):** ХҮИ нь өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийг хэмждэг. АНУ-ын инфляцийн хувь хэмжээг хэмжих хэмжүүр байдаг. АНУ-ын Хөдөлмөрийн Департаментас ХҮИ-г сар бүр гаргаж нийтэлдэг.

**Чөлөөт зах зээл:** Засгийн газрын оролцоогүйгээр эрэлт, нийлүүлэлтийн зарчмаар ажилладаг эдийн засгийн тогтолцоо.

**Чикагогийн худалдааны зөвлөл:** Гишүүдийнхээ өмчлөлд байдаг ашгийн төлөө бус корпораци. Гол үүрэг нь фючерс, опшонуудыг худалдаалах газраар хангах, зах зээлийн мэдээлэл цуглуулж тараах, клирингийн буюу төлбөр тооцоо барагдуулах механизмыг хэрэгжүүлэх, худалдааны дүрэм, журмуудыг сахиулахад оршино.

**Шинээр төрөн гарсан зах зээлүүд:** Хөгжиж байгаа эдийн засагтай орнуудын санхүүгийн зах зээлүүд.

**Шууд хөрөнгө оруулалт:** Аливаа компанийн дараа дараагийн шийдвэрт нөлөөлөхүйц хэмжээний хангалттай хөрөнгө оруулалт.

**Экспорт:** Гадаад оронд худалдан борлуулсан бараа, түүхий эд (бараа болон үйлчилгээ)

**Экспортлогч:** Гадаад орнуудын худалдаачид болон аж үйлдвэрийн хэрэглэгч нарт бараа, бүтээгдэхүүн худалдан борлуулж байгаа улс орон.

**Элэгдэл, хорогдол:** Бэлэн мөнгөний чөлөөт урсгалын нэг эх үүсвэрээр хангаж байдаг бэлэн мөнгөний бус зардал. Урт хугацаагаар ашиглагдах хөрөнгийн худалдан авсан өртгийг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид хорогдуулан хуваарилах хэмжээ.

**Эргэлт:** Хүчинтэй хугацаа нь дуусч байгаа хувьцаанаас олсон хөрөнгийг шинээр гаргах адилхан буюу ижил төстэй хувьцаанд дахин хөрөнгө оруулах

**Эрэлт:** Хэрэглэгчид бараа, үйлчилгээг ямар нэг өгөгдсөн үнээр, тодорхой хугацааны туршид худалдан авахад бэлэн байгаа буюу авч чадах тоо хэмжээ.

